

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-61
<hr/>	
1.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	13-25
2.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан	25-41
3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох	41-61

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Ганбаатар, Б.Найдалаа, О.Цогтгэрэл;
Тасалсан: Х.Баттулга, А.Ундраа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл хэлэлцэх асуудлын 1 дүгээрт Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцэх асуудлыг оруулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанки Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Эрдэнэсийн сангийн газрын захирал П.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монголбанки Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Э.Батшугар, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монголбанки

Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Эрдэнэсийн сангийн газрын захирал П.Эрдэнэтуяа нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг танилцуулав.

Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Т.Жамбаажамц оролцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Түндэвийн Жамбаажамцыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас Дэмбэрэлдашийн Баярсайханыг чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилж, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Улсын Их Хурлын Ж.Алдаржавхлан нэр дэвшигчдийн хэлэлцүүлгийг нэгтгэж явуулах горимын санал гаргаж, горимын саналыг гишүүдийн олонх дэмжив.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Б.Саруул, Л.Сонор, Ш.Хандсүрэн нар оролцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Булганы Саруулыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Лувсандоржийн Сонорыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Шагдаржавын Хандсүрэнг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарыг чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Гурав.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч М.Буяндэлгэр, О.Оч, Б.Энхбаяр нар оролцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: 1.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Оюунтөгсийн Очийг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Болдбаатарын Энхбаярыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Равсалын Ринчинбазар, гишүүний үүрэгт ажлаас Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам нарыг чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Дөрөв.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Н.Батнасан, Р.Даваадорж, Б.Мөнхзаяа, Б.Энх-Амгалан нар оролцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад нэр дэвшигч Р.Даваадорж хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: 1.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Намсрайн Батнасанг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Раднаасэдийн Даваадоржийг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Батбаатарын Мөнхзаяаг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Бямбажавын Энх-Амгаланг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас Цэрэндоржийн Батсүх, Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Тав.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Н.Ууганбаатар, С.Лхагвадорж, Г.Тэлмэн, Т.Тэлмэн, У.Хосжаргал, Д.Энхжаргал, Г.Эрдэнэбаяр нар оролцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын Ж.Алдаржавхлан, М.Мандхай, Н.Батсүмбэрэл, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар Нинжбатын Ууганбаатарыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Сугарын Лхагвадоржийг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Гэрэлтийн Тэлмэнг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Тунсагийн Тэлмэнг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Ундраагийн Хосжаргалыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Данзанбалжирын Энхжаргалыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Гомбын Эрдэнэбаярыг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Далрайн Даваасамбуу, гишүүний үүрэгт ажлаас Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарыг чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Зургаа.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч И.Батхүү, Т.Гарамжүгдэр, А.Даваасүрэн, Г.Золбоо, Д.Мягмарцэрэн, Д.Цолмон нар оролцов.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Сэддорж нар үг хэлэв.

Р.Сэддорж: 1.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Идэшийн Батхүүг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Төмөрбаатарын Гарамжүгдэрийг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Авирмэдийн Даваасүрэнг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Ганболдын Золбоог томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Дамдиндоржийн Мягмарцэрэнг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнээр Дорждэрэмийн Цолмонг томилуулахыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, О.Батнайрамдал, М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн санаачилсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж техник ажиллахгүй байгаа тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6

Бүгд: 14
57.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Тувааны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 21 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 23 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 21 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
18 цаг 11 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батсүмбэрэл, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Батчимэг гишүүн чөлөөтэй, Ж.Ганбаатар гишүүн чөлөөтэй, Найдалаа гишүүн болон Цогтгэрэл гишүүд чөлөөтэй. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1. Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны дарга, орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-ны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан. 2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. 3.Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 4.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар Орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох гэсэн 4 асуудал өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр товлогдсон байсан.

Үүнээс Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоол төслүүд дээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, 35.8.4 дэх заалтын дагуу Тамгын газраас анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах ёстой байгаа. Шахуу хугацаанд хууль зүйн дүгнэлт гаргаж амжаагүй байгаа тул өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулж байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудлын дараалал дээр 3-д байгаа Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 1 дүгээр асуудалд

оруулъя богино хугацаанд шийдэх учраас. Ингээд хэлэлцэх асуудал дээр санал байхгүй байна. Ингээд 3 асуудал байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 1. Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын тайланг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван танилцуулна. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Хэлэлцэх асуудал дээр горимын саналтай байгаа юм. Энэ юу вэ гэхээр нөгөө бид чинь өчигдөр орой болтол хуралдчихсан. Өнөөдөр нэлээн хуралдах шинжтэй байна. Үүдэнд баахан хүн хүлээлгэчхээд байдаг. Энэ нэг сонсголтой холбоотой асуудлаа эхлээд хэлэлцээд энэ үүдэнд байгаа хүмүүсээ шингэлбэл яасан юм. Ямар Сангийн яам явчих биш, хүлээж байна биз.

Р.Сэддорж: Энэ ганцхан тогтоол уншаад л, ганц санал хураагаад л болох юм байна. Зарчмын зөрүүтэй горимын саналаар санал хураалт явуулна. Батсүмбэрэл гишүүний хэлэлцэх асуудлын дараалал дээр, Батсүмбэрэл гишүүний гаргасан саналаар энэ Монголбанкны асуудлыг 1 дүгээр оруулахгүйгээр хуучнаар нь оруулъя гэсэн ийм санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт. 46,7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Энэ чинь би өөрөө.

Нэг. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван танилцуулна. Микрофоныг нээе.

Г.Энхтайван: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийг Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьж байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

1.2024 онд сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 тэрбум төгрөгийг түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн түр заалт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, түүх, археологийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад зарцуулахаар төсөвлөсөн. Эрдэнэсийн санд 2024 онд нэр бүхий 7 иргэнээс эд зүйл худалдаалах тухай өргөдөл ирүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар эдгээр эд зүйлс нь Монголбанкны эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулахад тавигдах шаардлагыг хангахгүй тул худалдан авах боломжгүй гэж шийдвэрлэсэн болно. Иймд төсвийн гүйцэтгэл тэг төгрөг байна.

2.2024 онд эрдэнэсийн сангийн гүйлгээ үндсэн санд орлогоор бүртгэсэн чингис хааны алтадсан хүрэл баримлын холбогдох зардлын төсөв 1,5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Их эзэн Чингис хааны хүрэл баримлын ажлын гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 747,4 сая төгрөг байна.

3.Монголбанк 100 ширхэг дурсгалын зоосны дээж үндсэн санд орлогод авахаар төсөвлөснөөс 2024 оны 10 дугаар, 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар байдлаар 116 ширхгийн гүйцэтгэлтэй байна.

4.Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн 1.4-өөс 1.7-д тусгасан 2018 оны 5 мянган төгрөгийн загвар 2 ширхэг, 38 оны 2 төгрөг 50 мөнгөний вексель 1 ширхэг, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн банкны мөнгөний чек 1 ширхэг, 20 мянгатын төгрөгийн мөнгөн тэмдэгтийн хэв 1 ширхгийг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэсэн. Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангийн сангаас 24550 ширхэг дурсгалын зоос болон алтан мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгаснаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос, 5840 ширхэг дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг худалдаалсан байна.

6.Үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны төсөвт 2,9 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд Монголбанк Чингис хаан музейтэй байгуулсан 0523244 тоот Чингис Хаан музейд үзэсгэлэн зохион байгуулахад хамтран ажиллах гэрээний дагуу Чингис Хаан Үндэсний музейн 9 дүгээр давхрын хүндэтгэлийн өргөөнд дэглэлт байршуулах засварын зардалд 2,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Эрхэм гишүүдэд 2025 оны Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ, сангийн орлого, зарлагын төсвийг та бүхэнд танилцуулъя. Монголбанкнаас эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг 2025 онд дараах байдлаар нэмэгдүүлж, үндсэн санд орлогоор бүртгэхээр төлөвлөж байна. Үүнд Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, сэргээн засварлалт, байгалийн түр заалт худалдан авах, археологи, түүхийн судалгааны эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөг зарцуулах.

2.Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээжийг орлогоор бүртгэх.

3.1945 оны зоосон мөнгө 2000 ширхгийг эрдэнэсийн сангийн тэнцлийн гадуурх данснаас үндсэн орлогод бүртгэх.

4.Монголбанкны хүндэт банкир жижиг тэмдэг, хайрцаг нийт 3 ширхгийг тэнцлийн гадуурх данснаас үндсэн сангийн байнгын бус хэсэгт бүртгэх зэрэг болно. Мөн 2025 онд үйлдвэрлэгдэх дурсгалын зоос болон бусад эд зүйлсийг гүйлгээ санд орлогоор бүртгэнэ. Гүйлгээ сангаас 24500 ширхэг дурсгалын зоос, гулдмай, үрлэн мөнгийг зарлагдахаар тусгаснаас худалдах зориулалтаар 24300 ширхгийг, зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхгийг, мөнгө, зэс дурсгалын зоос зарцуулахаар тусгалаа. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8-д сэргээн засварлах арчлах гэж заасны дагуу Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дэх эд зүйлсийн арчилгаанд 200 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн болон үндсэн сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төслийг хэлэлцэж өгөхийг **хүсье**.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Г.Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, П.Эрдэнэтуяа Монголбанкны Эрдэнэсийн сангийн газрын захирал. Тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье? Батшугар гишүүнээр тасалъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би яах вэ зүгээр эрдэнэсийн сангийн асуудал хууль тогтоомжийн хүрээнд л цэгцтэй явдаг гэдэгт зүгээр найдаж байна. Тэгээд Эрдэнэсийн сан музейн үйл ажиллагааны хадгалалт хамгаалалт, баяжуулалт, орлого, зарлагын байдал, хөндлөнгийн аудит буюу хяналт шалгалтаар хийсэн дүгнэлт, энэ дүгнэлтийн талаарх авч хэрэгжүүлсэн арга хэмжээний асуудал ер нь хэрхэн, ямар байдалтай явдаг вэ? Нэг ерөнхий мэдээлэл өгөөч гэж хүсэж байгаа юм. Уг асуудлаар жишээ нь манай өчигдрийн Монголбанкны Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа зарим нэр дэвшигчид энэ асуудлыг зайлшгүй цэгцэлж, үнэлэлт дүгнэлт өгөх ёстой гэж ярьж байсан. Тэгэхээр ийм зүйлүүд дээр Энхтайван Ерөнхийлөгч Монголбанк ямар арга хэмжээ авч байна вэ? Энэ үйл ажиллагаа яг хатуу хяналтдаа байж чадаж байгаа юу? Энэ үйл ажиллагааг чинь хариуцаж байгаа хүмүүс чинь ашиг сонирхлын зөрчилд ордог уу? Янз бүрийн байдлаар ховор янз бүрийн юм цуглуулдаг хүмүүстэй хамаарал бүхий ийм этгээдүүдийн л нэр сонсогдоод байдаг. Тэгээд энэ ер нь яаж явдаг юм бэ? Энэ дээр мэдээлэл өгөөч?

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүнийг нэмье. 4 номер хариулт, 4 үү? 4.

Г.Энхтайван: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын эрдэнэсийн сан нь 1983 онд тухайн үеийн Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Үнэт зүйлс, эрдэнэсийн сангийн улсын фонд нэртэйгээр анх байгуулагдсан. Тэгээд 1994 онд Эрдэнэсийн сангийн хууль батлагдсанаар Төв банкны нэг бүрэлдэхүүн хэсэгт ороод явж байгаа. Сүүлд 2022 онд Эрдэнэсийн сангийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан байгаад байгаа. Тэгээд Эрдэнэсийн санд яг одоогийн байдлаар үндсэн санд нийтдээ 1,1 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эд зүйлс хадгалагдаж байгаа. Эрдэнэсийн сангийн үндсэн сан хөмрөгт 2663881 ширхэг эд зүйлс, гүйлгээ санд 40017 ширхэг үнэт зүйлс хадгалагдаж байгаад байгаа.

Эрдэнэсийн сангийн тухай хууль шинэчлэн батлагдсанаар Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн үндсэн болон гүйлгээ сан дээр байнгын ба байнгын бус гэж хуваагдаж байгаа. Байнгын хэсэгт Соёлын өвийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хуулиар түүх соёлын хосгүй үнэт, үнэт гэж зэрэглэл авсан эд зүйлсийг хадгалдаг. Эрдэнэсийн сангийн гүйлгээ санг Улсын Их Хуралд танилцуулснаар Улсын Их Хурлын тогтоолын дагуу Төв банкны эрдэнэсийн сан зоос болон бусад бүтээгдэхүүн зүйлсийг худалдаалдаг байгаад байгаа. Тооллого, хяналт шалгалттай холбоотой асуудлыг жил болгон манай дээр олон улсын аудитын байгууллага аудит хийдэг. Мөн Төв банкны дотоод хяналтын газраас жил болгон эрдэнэсийн сан дээр тооллого, аудит явагддаг. Олон улсын аудит болон Төв банкны дотоодоос хийгдэж байгаа аудитын дүн зөрөөгүй, ерөөсөө зөрдөггүй.

Эрдэнэсийн сангийн эд хөрөнгийг шамшигдуулсан, эрдэнэсийн сангийн эд хөрөнгө алдагдсан зүйлс яг одоогийн байдлаар байхгүй байгаа.

Эрдэнэсийн сангийн харуул хамгаалалт болон хадгалалттай холбоотой асуудал Эрдэнэсийн сангийн тухай хуулиар зохицуулагддаг. Яг харуул хамгаалалт, байршилтай холбоотой асуудал улсын нууцад хамаарагдаад явдаг. Эрдэнэсийн сангийн харуул хамгаалалттай холбоотой асуудлыг гэрээний үндсэн дээр цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг байгаад байгаа. Гадуур олон нийтийн зүгээс эрдэнэсийн сангийн эд зүйлс алдагдсан энэ тэр гэсэн янз янзын яриа гардаг. Гэхдээ энэ тооллогын дүнгээр баталгаажууд явдаг учраас ор үндэсгүй зүйл гэж хэлэхээр байна.

Р.Сэддорж: 5 номер нэмж хариулах уу? Сайнзориг гишүүн тодруулъя. Жаргалан гишүүнийг нэмээрэй.

П.Сайнзориг: Ойлголоо. Өчигдөр харин нэр дэвшигчдийн зүгээс Монголбанктэй холбоотой хууль бус янз янзын юм явахаар буцааж няцаалт хийдэггүй нь энэ байгууллага хаалттай янз янзын гэдэг өнцгүүдийг гаргаж ирж өөрөө өөрсдийгөө танилцуулж байсан л даа. Зарим нэр дэвшигч эрдэнэсийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ер нь нэг хөндлөнгийн аудит хяналт шалгалт хийж, энэний мөрөөр зарим арга хэмжээ авах ёстой гэж үзээд байгаа юм. Тэгэхдээ үеийн үед нь яах вэ би шулуухан л хэлье. Ер нь зүгээр зарим үнэт зүйл цуглуулдаг ийм сонирхолтой хүмүүсийн хамаарал бүхий этгээдүүд энэ санг хариуцаад явж байдаг гээд өөрийн чинь хажууд сууж байгаа хүнийг л би хэлж байна л даа. Тэгээд ийм юм байхад заавал ингээд ажиллуулаад байдаг шаардлага нь юу юм бэ? Ингээд олон нийт эргэлзээд байна. Тэрийг чинь хүртэл сонсголд орж ирж байгаа нэр дэвшигчид яриад байгаа байхгүй юу. Ингээд энэ үйл ажиллагааг хууль бус зүйлүүдийг няцаалт хийж чаддаггүй, ингэдэг тэгдэг гээд. Би зүгээр баримттай юм ярьж байгаа шүү. Энэ өөрөө эргээд нэр дэвшигч нарын ярьсан.../минут дуусав/

Р.Сэддорж: Санал уу? Хариулт 4 номер.

Г.Энхтайван: Эрдэнэсийн санд жил болгон аудит ордог гээд би хэлсэн. Өнгөрсөн жилийн байдлаар олон улсын нэр бүхий PWC агентлаг эрдэнэсийн сангийн үйл ажиллагаанд аудит хийсэн байгаад байгаа. Аудит болон түрүүн хэлсэн Монголбанкны дотоод аудитын газрын шалгалтын дүн зөрдөггүй. Энэ яг олон улсын жишиг стандартынхаа дагуу яаж хийгддэг вэ гээд тооллого нь бүрэн гүйцэт явж байгаа. Монголбанканд ажиллаж байгаа албан хаагчдын хувьд манай эрдэнэсийн сангийн ажилтан, албан хаагчдын хувьд маш олон жил ажилласан дийлэнх нь Төв банкандаа 10 гаруй жилээс дээш ажиллаж байгаа. Таны түрүүний нэр цохоод хэлж байгаа манай Эрдэнэсийн сангийн захирлын хувьд 2016 оноос хойш Эрдэнэсийн сангийн захирлаар ажиллаж байгаа. Төв банканд ажиллаад 10 гаруй жилийн хугацаанд Төв банкны бусад мэргэжлийн газруудад ажиллаж яваад дотроо солигдоод Эрдэнэсийн сангийн газарт шилжээд ирж байгаа. Төв банкны зүгээс ажилтан, албан хаагчдаа илүү тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, газар хооронд нь сэлгэн ажиллуулах.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхбаярын Батшугар гишүүн.

Ж.Батшугар: Баярлалаа. Өнгөрсөн онд Эрдэнэсийн сангийн төсөв 2 тэрбум төгрөг байсан. Тэгэхээр өнгөрсөн онд ямар нэгэн хосгүй үнэт зүйл Монголбанк худалдаж авсан уу гэж асууя?

2-т нь нийт М2 43 их наяд байгаа. Үүний хэдэн төгрөг нь бэлнээр байгаа вэ? Бэлэн мөнгөөр.

3-д нь өчигдөр Мөнгөний бодлогын хороо хуралдсан Монголбанкны. Тэгээд заавал байлгах ёстой банкны нөөцийг 2 хувиар нэмэгдсэн нэмсэн. Энэ нь банкны салбарын хөрвөх чадварт яаж нөлөөлөх вэ? 2-т нь зээлийн хүүд нөлөө өгөх үү, үгүй юү? Миний харж байгаа зээлийн хүүд нөлөөлнө гэж бодож байгаа юм ихсэх нь. Яаж вэ гэвэл банкнуудын өөрсдийнх нь эх үүсвэрийн зардал нь хэвээрээ байгаа. Харин үүнийг эргэлдүүлэх ёстой байгаа банкны мөнгө нь өөрөө Монголбанканд дээр гацна. 3 хувийн ... хүүтэй. Тэгэхээр ашигт ажиллагаагаа болон зардалдаа нэмэхийн тулд зээлийн хүүгээ л өсгөхөөс өөр арга байхгүй банкнуудад. Тэгэхээр энэ зүйл болох уу, үгүй юү?

3-д нь хэр хэмжээний мөнгийг Төв банк энэ 2. хувиар нэмж өөр дээрээ байршуулах гээд байна гэдгийг хариулж өгөөч.

Сүүлийн асуулт нь юу байна геополитикийн хүнд нөхцөл байдлаас болоод Орос улсад өнгөрсөн оны 11 дүгээр сард санкц тавьсан банкнуудад. Үүнтэй холбоотойгоор Монголын Орос улсын нефтийн бүтээгдэхүүн импортлохтой холбоотойгоор төлбөр тооцоонд нь ямар нэгэн гачигдал гарах уу гэж асууя. Яагаад гэвэл бид чинь бараг 2,5 тэрбум долларын импорт нефть авдаг жил болгон. Тэгэхээр хэрвээ нефтиэ худалдаж авч чадахгүй төлбөрийн асуудал нь асуудалтай болчихвол энэ бол Монгол Улсын эдийн засагт маш томоор нөлөөлнө л дөө.

Өчигдрийн энэ шийдвэртэй холбоотойгоор эдийн засагт хуримтлах банкны салбарын эрсдэл дээшээ, доошоо нэмэгдэх үү, ямар нэгэн нөлөө байгаа юу, үгүй юү?

Инфляц бол бодлогын онилсон түвшнээс давчихсан байна 9 хувь. Монголбанкны мөнгөний бодлого дээр 5 дээр +2, -2 гэж явж байгаа. Тэгэхээр энэ 9 хувь улс даяар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 9,1 хувиар гарсан. Энэ нь үндсэн шалтгаан нь юу байсан бэ? Тог, дулааны төлбөрийг нэмсэн нь нөлөөлсөн үү гэх мэтчилэн асуулт асууя? Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Г.Энхтайван: Батшугар гишүүний асуултад хариулъя. 2024 онд Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулахад худалдан авалт хийгдээгүй. Түрүүн танилцуулга дээр хэлсэн 7 иргэнээс эд зүйл худалдан авах санал ирүүлсэн боловч манай мэргэжлийн зөвлөл хэлэлцээд энэ дээр шаардлагагүй гэсэн тийм дүгнэлт гаргаж өгсөн байгаад байгаа.

Өчигдөр Төв банкны Мөнгөний бодлогын хороо хуралдаад бодлогын шийдвэрүүдийг гаргасан. Тэгээд банк санхүү, эдийн засаг, зах зээлийн өнөөгийн байдал, эдийн засгийн гадаад орчны эрсдэлээ харгалзан үзээд мөнгөний бодлогын хүүг 10 хувиар хэвээр хадгалсан. Банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хэмжээг 2 хувь нэмэгдүүлж тус бүр 13, 18 хувь

болгосон байгаад байгаа. Заавал байлгах нөөцийн хэмжээ 2 хувь нэмэгдэхэд нийтдээ 890 тэрбум төгрөгийг арилжааны банкнуудаас Төв банкин дээр заавал байлгах нөөцийн хэмжээнд нэмэлтээр авчирч байгаа юм. Нэмэлтээр. Энэ 890 тэрбум төгрөгийн 650 орчим тэрбум төгрөг нь арилжааны 3 том банк болох ХААН, Худалдаа Хөгжил, Голомт банкнаас татагдаж орж ирж байгаа гэсэн үг.

Инфляцын хувьд 2024 оны 12 сарын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 9,1-тэй гарлаа. Тэгээд инфляц Төв банкны зорилтот түвшний дээд хязгаарыг давахад цахилгааны үнэ тарифын өөрчлөлт, импортын мах импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нэлээн нөлөөлсөн. Төрийн зохицуулалттай гэж нэрлэгдээд байгаа бараа, бүтээгдэхүүний буюу энэ цахилгааны үнийн нэмэлт инфляцад 2,3 хувийн нөлөө үзүүлсэн судалгаа байгаад байгаа. Мөн махны үнийн өсөлт харьцангуй өндөр байсан. Бидний төсөөллөөс өндөр давсан. Жил болгон 11, 12 сард хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулаад махны үнэ буурдаг. Гэхдээ энэ жилийн хувьд махны үнэ, үнийн өсөлт харьцангуй өндөр байлаа. Энэ нь өнгөрсөн оны хавар болсон цас зудын нөхцөл байдлаас хамааран нийлүүлэлт дээр үүссэн шокийн байдлаас болоод махны үнэ харьцангуй өндөр он авлаа.

Тэгэхээр импортын, мөн импортын бараа, бүтээгдэхүүний үнэ харьцангуй буусангүй. Тэгэхээр инфляцын хувьд Төв банкны зорилтот түвшний дээд хязгаарыг давж байна, 9,1 хувь явж байна. Оны төгсгөлд мөн Эрдэнэс Тавантолгой компанийн ноогдол ашгийн урьдчилгаа төлбөр гэх мэтчилэн эдийн засгийг идэвхжүүлэх үйл, санхүүгийн үйл ажиллагаа явагдсантай холбогдуулаад инфляцыг Төв банкны зорилтот түвшинд хадгалах үүднээс өчигдөр Төв банкны Мөнгөний бодлогын хороо ээлжит бусаар хуралдаад энэ мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах арга хэмжээ авсан. Инфляцын хувьд мэдээж Төв банк зорилтот түвшнээс хэрвээ давах юм бол 3 сард болох Мөнгөний бодлогын ээлжит хорооны хурлаар Төв банкны мөнгөний бодлогын зорилтыг хангах үүднээс төлөвийг илүү чангаруулаад явна.

Зээлийн хүү дээр мэдээж арилжааны банкны чөлөөт эх үүсвэрээс 890 гаруй тэрбум төгрөгийг Төв банкин дээр татаж авчирч байгаатай холбогдоод л зээлийн хүү дээр тодорхой хэмжээний өсөлт гарна. Ер нь Төв банкны судлаач нарын хийсэн судалгаагаар бодлогын хүү жишээлбэл 1 хувь нэмэгдэхэд 8-аас 9 сарын дараа зээлийн хүн дээр 0,6 хувийн эффект өгдөг. Заавал байлгах нөөц илүү хурдан хугацаанд хугацааны хувьд шууд гарсан өдрөөсөө хэрэгждэг учраас илүү эффе́ктив, илүү үр дүнтэй байдаг. Энэ дээр мэдээж зээлийн хүү дээр одоо хөтөлбөрийн зээлийг оруулаад зээлийн дундаж хүү 16,6 хувьтай байгаа. Тэгэхээр энэ дээр 0,1-ээс 0,2 хувийн нөлөө үзүүлнэ гэж Төв банк үзэж байгаа.

Гадаад нөхцөл байдалтай холбоотой төлбөр тооцооны хувьд манай улс ОХУ-аас импортоор авч байгаа шатахуун болон цахилгаан эрчим хүчний төлбөрийг.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцэтгэж хариулъя 4 номер.

Г.Энхтайван: Өнгөрсөн 11 дүгээр сард АНУ-ын Сангийн яамнаас тавигдсан тэр хориг арга хэмжээний хүрээнд нэлээн өндөр зэрэглэлийн хориг байсантай холбогдуулаад манай гадаад төлбөр тооцоог голлон гүйцэтгэж байсан bank of china-ийн зүгээс манай ОХУ руу явуулж байсан төлбөр тооцоог явуулахыг зогсоосон байсан. Гэхдээ Төв банк, Сангийн яам, Уул уурхайн яам, Гадаад

харилцааны яам, мөн Америкийн холбогдох байгууллагуудтай нэлээн олон удаагийн уулзалт семинаруудыг хийж, харилцан ярилцсаны үндсэн дээрээс төлбөрийн шинэ сувгийг нээсэн байгаад байгаа. Манай улсын хувьд гадаад төлбөр тооцоон дээр Оросын, тэр дундаа ОХУ руу хийгдэж байгаа бензиний төлбөр дээр гацаад байсан төлбөр тооцоо байхгүй. 11 сараас хойш яваагүй байсан төлбөр тооцоог сая өнгөрсөн долоо хоногт явуулаад бүгдээрээ дууссан. Нийтдээ 200 гаруй сая долларыг давтамжтайгаар явуулаад дуусгасан байгаад байгаа. Ер нь төлбөр.../минут дуусав/

Р.Сэддорж: Батшугар гишүүн тодруулъя.

Э.Батшугар: Өнгөрсөн онд нийт банкны салбар зээлийн өсөлт хэдэн хувьтай байсан бэ? Ангилбал хэрэглээний зээл болон бизнес зээл гэж ангилбал бизнесийн зээл ер нь сүүлийн 3 жилийн өсөлт багатай байсан. Харин өнгөрсөн онд өсөж чадсан уу, үгүй юу? Бизнесийн зээл чинь өөрөө эдийн засгийг идэвхжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг, ажлын байрыг бий болгодог. Тэгэхээр өчигдөр заавал байлгах ёстой төгрөг болон валютын нөөцөө багасгаснаар нийтээр нь л зээлийг хумьж байна гэж ойлгож болно л доо. Тэгэхээр дан нийтээр нь хумихгүй бизнесийн зээлээ хэвээр явуулах ийм орчин бүрдүүлэх тийм шийдвэр байгаа юу, хийж болох уу гэж асууя.

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Г.Энхтайван: 2024 оны 12 дугаар сарын байдлаар банкны банкнуудын зээлийн үлдэгдэл оролцоогоор 33,7 хувиар өсөөд, 35,6 их наядтай байна. Үүнээс хэрэглээний зээлийн болон хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 36,5 хувийн өсөлттэй байсан. Тэгэхээр хэрэглээний зээл харьцангуй өндөр өсөлттэй байсан. Энэ нь хэд хэдэн нөхцөлөөр төлбөрийн тэнцэл дээр илэрч байгаа. Жишээлбэл өнгөрсөн жил манайхан 113 мянган, 123 мянган автомашин жишээлбэл импортоор орж ирсэн. Энэ дээр 1,3 тэрбум долларын гадаад импорт буюу импортыг санхүүжүүлсэн байсан гэдгээс харагдаж байгаад байгаа. 2023 он болон 24 онд дараалаад Төв банкнаас батлагдсан тэр мөнгөний бодлогын үндсэн чиглэл өргөн барьсан Мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр хэрэглээний зээлээс илүүтэйгээр хөрөнгө оруулалтын болон бизнесийн зээлийг идэвхжүүлэх, тэдгээрийн нөхцөл.../минут дуусав/

Р.Сэддорж: Болсон уу? Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууна.

Н.Батсүмбэрэл: Энэ 2024 оны гүйцэтгэл дээр нь аудит орсон гэсэн үү? Тэгээд энэ гаднын аудит материалыг нь бид дээр байхгүй байх шиг байна. Энийг материалыг өгч болох уу 1.

2-т нь энэ Чингис хаан баримлыг тээвэрлэх, угсралт, гэрэлтүүлгийн зардал гээд нэг зардал явж байгаа. Энэ ямар учиртай зардал байсан юм бэ?

Дээрээс нь Чингис хааны баримлын жижгэрүүлсэн хувилбараар 2 ширхгийг хийлгэсэн гээд нэг ийм тайлан дотор явж байна. Энэ ямар учиртай вэ? Тэгээд 2025 онд 200 сая төгрөгийн төсөв тавьсан гэж байгаа. Тэгээд энэ энийгээ хангалттай гэж үзэж байгаа юу гэсэн ийм асуулт байна.

Р.Сэддорж: Хэн нь хариулах вэ? 4 номер.

Г.Энхтайван: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Яг одоогийн байдлаар олон улсын аудитын PWC компани Монголбанк дээр аудит эхлээд явж байгаа. Эрдэнэсийн сангийн тухайд тооллого яг өнөөдрийн байдлаар хийгдээд явж байгаа. Ер нь хуулийн хугацааныхаа дагуу бид бүхэн энэ оны 4 дүгээр сард Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд аудитын тайланг гарахаар нь танилцуулдаг.

Чингис хаан баримлын хувьд энэ Чингис хааны музейд музейн хамгийн дээд талын давхарт Их эзэн хааны алтадсан хүрэл баримлыг бид бүхэн хийж Соёлын яам, Монголбанк 2 хамтраад хийж бүтээж залсан байгаад байгаа. Энэ бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны тогтоол, мөн Засгийн газрын тогтоол, мөн 22, 23, 24 оны Эдийн засгийн байнгын хорооны эрдэнэсийн сан төсвийн тогтоолоор дагаж энэ Их эзэн Чингис хааны алтадсан хүрэл баримлыг бид бүхэн хийж залсан. Энэтэй холбоотойгоор холбогдох зардлуудыг өнгөрсөн 2022, 23, 24 онд тусгаад явсан. Одоогийн байдлаар Их эзэн хааны алтадсан баримлыг хийж гүйцэтгээд угсрах ажил бүрэн хийгдэж дууссан байгаад байгаа. Тэр нэг жижиг макеттай, жижиг баримлын жижиг хувилбарыг Төв банкны эрдэнэсийн сан өөрсдөө жижиг хувилбараар хийж гүйцэтгүүлээд, эрдэнэсийн сан дээр үзмэр хэлбэрээр залсан байгаа. Энэ дээр тэр зардал дээр 250 орчим сая төгрөг, 251 сая төгрөг зарлагдсан байгаад байгаа.

Нийтдээ Чингис Хаан музейн 9 давхрын тэр хүндэтгэлийн өрөөнд дэглэлт байршуулах засварын зардалд 2,9 тэрбум төгрөгийг өнгөрсөн жилийн төсвөөс зарцуулсан. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухайн үед нь танилцуулж байсан. Энэхүү үзмэрийн танхимын дэглэлт, гэрэлтүүлэг, чимэглэл засварт энэ бүхэн зарцуулагдсан гэж ойлгож болно. 200 сая төгрөгийн тэр төсвийн хувьд бид бүхэн өмнөх жилүүдийн гүйцэтгэлтэйгээ уялдуулаад хүрэлцээтэй юм болов уу гэсэн тийм тооцооллоор энэ удаа Улсын Их Хуралд оруулж ирсэн байгаа.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Ойлголоо. Тэр Чингис хааны баримлыг Чингис хааны музейд зориулж хийлгэсэн юм байна гэж ойлголоо, 13 тэрбум төгрөгөөр нийт өртөг байгаа юм байна. Үүнийгээ жижгэрүүлсэн 2 хувилбар хийж байгаа юм байна. Энэ нь энэ өртөгтөө багтаж байгаа юу 1 дүгээрт? 2 дугаарт нь нэг нь мэдээж Монголбанк руу очиж байгаа юм байна. Нөгөөхийг нь хаана хадгалахаар тэр жижгэрүүлсэн хувилбарын 2 дахь нь ямар учиртай захиалга юм бэ гэж тодруулж асууя.

Тэгээд түрүүн тэр Сайнзориг гишүүний асуудаг асуулт бол маш чухал юм шүү. Их Хурлын гишүүдийн хувьд тэр хажууд нь сууж байгаа хүн өөрөө хариулмаар байгаа юм. Тэр янз бүрийн хэвлэл мэдээллээр яваад байдаг асуудлууд дээр үнэн юм уу, худлаа юм уу?

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Г.Энхтайван: 2 ширхгийг хоёуланг нь эрдэнэсийн санд хийж гүйцэтгээд, эрдэнэсийн санд бүртгэж авч байгаа 2 ширхгээр. Нийт төсөвт өртөг 13,2 тэрбум төгрөгтөө багтаж байгаа. Үлдэгдлийг нь Эрдэнэтуяа захирал.

Р.Сэддорж: 5 номер нэмж хариулах уу, 5 номер.

П.Эрдэнэтуяа: Та бүхний өнөөдрийн амгаланг айлтгая. Тэгээд нэмэлт мэдээлэл, миний талаар асууж байгаад би нэмэлт мэдээлэл өгье. Би Монголбанкны эрдэнэсийн санд 2017 оны 1 сард томилогдсон. Жил бүр тооллогын хөндлөнгийн аудитын хамтарсан тооллогын тайланг Улсын Их Хуралд тайлагнадаг, жил бүрийн төсвийн тайланг Улсын Их Хуралд мөн тайлагнадаг. Надтай холбоотой яригдаад байгаа асуудал дээр жишээ нь миний ойлгосноор өчигдрийн хуралдаанаар Байнгын хорооны хуралдаанаар яригдсан Энхжаргал Дэд ерөнхийлөгчийн хийх ажлын төлөвлөгөөнд Эрдэнэсийн сантай хамааралтай ажил орсон юм байна гэж ойлгосон.

Гэхдээ Энхжаргал Ерөнхийлөгчийн хувьд сүүлийн 10 жил Монголбанканд ажиллаагүй. Тэгэхээр дотоод тайлан болон санхүүгийн тайлангуудыг авч би танилцаагүй гэж бодож байна. Миний хувьд 2017 оны 1 сарын 1-нээс өмнөх ямарваа нэгэн эрдэнэсийн сантай.../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер гүйцээж хариулъя.

П.Эрдэнэтуяа: Эрдэнэсийн сантай хамааралтай ямарваа нэгэн 2017 оны 1 сараас өмнөх асуудалд миний бие ямар ч хамааралгүй. Намайг тухайн үед 2016 он, 17, 18 онд Монголбанканд оруулсан шалгалтын хүрээнд гүтгэж байсан Улсын Их Хурлын гишүүн Аюурсайхан өнөөдөр өөрөө гэмт хэрэгтэн болчихсон явж байгаа.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалан: Монголбанкнаас Монгол Улсын Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэл болоод 2025 оны төсвийн төлөвлөгөөгөө оруулж ирж байгаа юм байна. Тэгэхээр саяын Батсүмбэрэл гишүүний асуусан асуултыг би давхар тодруулъя. Чингис хааны музей гэж музейг тухайн үед 20, 21 онд маш өндөр төсвөөр барьж байгуулж байсан. Буруу санаагүй бол 50 гаруй тэрбумаар музейн барилга байшинг барьсан, асуудлууд гарсан. Дараа нь тодотгоод ерөнхийдөө бараг 100 орчим тэрбум төгрөг болсон. Үүн дээр нэмэгдээд энэ хүндэтгэлийн өргөө гэдэг дээр Чингис хааны баримлыг 13 тэрбумаар Монголбанкны санхүүжилтээр хийсэн юм байна гэж ойлголоо. Зөв үү? Тэгээд энэ 13 тэрбумаар барьсан баримлаас гадна үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны Эрдэнэсийн сангийн төсөвт 2,9 тэрбум төгрөг төсөвлөөд, үүнээс танхимын засвар дэглэлтийн ажилд 2,3 тэрбум төгрөгийн төлбөр төлөхөөс 1,6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна гэж байна. Тэгэхээр үндсэндээ тэр нөгөө энэ 9 давхрын хүндэтгэлийн танхим үзмэртэйгээ нийлээд 13 тэрбум дээр нэмээд 14,6 тэрбум болж байгаа юм байна Монголбанкнаас гарсан зардал нь. Энийг тодруулъя.

Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсөв гээд 1 хүснэгт байна л даа энд. Тэгэнгүүт энэ Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулах франчайз болон дурсгалын дээж, мөнгөн тэмдэгтийн хэв, зоосон мөнгө энэ тэр гээд тэгээд ямар ч тийм үнийн дүн тавилгүй зүгээр тоо ширхэггүй тавьчихсан, гүйцэтгэлээр энэ тэр гэгчихсэн ийм зүйл оруулж ирэх нь хэр зохимжтой вэ? Энэ дээр үнийн дүн тавигддаггүй юм уу? Хэрэв төсөв батлуулна гэж үзэж байгаа бол төсөв гэдэг дээр чинь үнийн дүн явах ёстой гэж

ойлгоод байгаа шүү дээ. Гэтэл зүгээр тоо ширхэггүйдээ л тавьчихсан ийм зүйл оруулж ирсэн байна. Энийгээ нэг тайлбарлаад өгөөч. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Г.Энхтайван: Жаргалан гишүүний асуултад хариулъя. 2022 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 02 дугаар зөвлөмж, мөн ЗГ-ын тогтоолоор Чингис хаан музейн дээд талын 9 давхарт Төрийн хүндэтгэлийн ёслол үйлдэх танхимыг засаж тохижуулах, Их эзэн Чингис хааны алтадсан хүрэл баримлыг тухайн өргөөнд залах тийм үүргийг Төв банканд өгсөн байгаад байгаа. Нийтдээ баримлыг бүтээх зардал 13 орчим тэрбум төгрөг болсон. Гэхдээ энэ бол эрдэнэсийн сангийн өөрийн хөрөнгөөр бүртгэгдэж байгаа, зардал бол биш. Өөрийн хөрөнгөд. Тэгээд тухайн баримал маань өөрөө Төв банкны эрдэнэсийн сангийн үндсэн санд байнгын хэсэгт бүртгэгдээд явж байгаа. Тэгэхээр энэ бол зардал биш. Төв банкнаас тухайн дээд талын 9 давхрын тэр үзмэрийн танхимыг дэглэх гэж бид бүхэн нэрлээд байгаа. Засаж тохижуулах, тухайн Их хааны алдчихсан барималтай нийцтэй байлгах тийм дэглэлтийг зохион байгуулсан. Энэ дээр засварын зардал дээр таны хэлсэн тэр 2,9 тэрбум төгрөг төсөвлөгдөөд, 2,3 тэрбум төгрөг зарлагадаад явсан. Энэ зардал хэлбэрээрээ явж байгаа.

Зоосны үнийн хувьд бид бүхэн яг тухайн зоос маань өөрөө ямар материалаар хийгдэх вэ, хэдэн ширхгээр хийгдэх вэ, захиалагч тал нь хэдээр захиалах вэ, жишээлбэл зэсээр хийх юм уу, мөнгөөр бүрэх юм уу, алтаар бүрэх юм уу гэдэг маань өөрөө тэр тухайн захиалагч талын буюу зоос захиалагчийн өөрийнх нь хүсэл байдаг учраас бид бүхэн шууд тэдэн төгрөгийн үнэтэй, тийм орцтой гэж тавихад харьцангуй хүндрэлтэй. Ерөнхий дундаж дүнгээр нь тооцоод явдаг. Зоос болгон өөрсдийн үнэ нь өөр байдаг. Тоо хэмжээ, орц, хэлбэр, дүрс гэх мэтчилэн зүйлсээсээ хамаардаг. Жишээлбэл өнгөрсөн жил Тагнуулын ерөнхий газар, ЗГХЭГ энэ тэр гэх мэтчилэн байгууллагууд өөр өөрсдийн зоосыг захиалж хийлгэсэн байгаад байгаа. Тэгээд зоос болгон харьцангуй өөр, өөр үнэтэй байсан.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Чингис хааны баримлыг бүтээх үзэсгэлэнг дэглэх асуудал болохоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн захирамжтайгаар явсан гэж ойлголоо. Тэгэхдээ ер нь Монголбанкны буюу Эрдэнэсийн сангийн өмнөх түүхэнд ч гэдэг юм уу энэ үзэсгэлэн дэглэх гэдэг дээр ийм хөрөнгө төсөв гаргаад явсан тийм туршлагауд байдаг юм уу? Ер нь цаашид нэг ийм юмнууд хийгээд байх юм уу? Энэ чинь нэг аягүй том үүд хаалгыг нээчхэж байна л даа. Монголбанкны үндсэн чиг үүргээс гадуур тусдаа ийм зардлуудыг санхүүжүүлээд явах үүд хаалга нээж байгаа юм болов уу гэсэн тийм зүйл харагдаж байна. Тэр зооснуудын, зооснууд бол мэдээж хэрэг өөр өөрсдийн үнэ өртөгтэй, өөр өөрсдийнх нь юугаар хийгддэг байх. Гэхдээ та хэд нэгэнтээ ямар төрлийн зоос хийхээ төлөвлөөд, хэдэн тоо ширхгээр хийхээр төлөвлөөд төсвөө оруулж ирж байгаа нөхцөлд энэ бүгдийнхээ яг нөгөө мөнгөн дүнг, үнийн дүнг тавиад төсвөө.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

Г.Энхтайван: Жаргалан гишүүний асуултад тодруулъя. Эрдэнэсийн сангийн тухай хуулиар Төв банк эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулах, хадгалах, хамгаалах, арчлах, тордох үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд эрдэнэсийн

санг баяжуулах үндсэн үүргийнхээ дагуу Чингис хааны алтадсан хүрэл баримлыг бүтээж байгаа юм. Энэ бол эрдэнэсийн сангийн баланс дээр бүртгэгдээд, хөрөнгө болоод бүртгэгдээд явж байгаа. Үзмэр зохион байгуулах дэглэх ажлын хүрээнд Төв банк өмнөх, өмнөх жилүүдэд эрдэнэсийн сангийн үзмэрийн танхимыг бэлдээд явдаг байсан. Төв банкны байрны 1 дүгээр давхарт эрдэнэсийн сангийн үзмэрийн танхим байдаг. Энийгээ бид бүхэнд тохижуулаад, дэглээд олон нийтэд, хүүхэд залуучуудад үзмэр хэлбэрээр үзүүлдэг. Чингис хааны музей байгуулагдсаны дараа Төв банкны эрдэнэсийн сангийн голлох түүх, соёлын хосгүй үнэт, үнэт зэрэглэлтэй эд материал үзмэрүүдийг Чингис хааны музейд гэрээний дагуу байршуулж.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя, 4 номер.

Г.Энхтайван: Гэрээний дагуу үзүүлж байгаа. Яг энэ хүрээнд Төв банкнаас тэр дээд талын 9 давхрын үзмэрийн танхимд өөрсдийн тэр манай баланс дээр бүртгэлтэй хааны баримал тэнд байгаа учраас бид бүхэн тэр дэглэлт гэдгийг давхар хийж гүйцэтгэж байгаа. Ер нь иймэрхүү зүйлсийг Төв банкнууд дэлхийн бусад Төв банкнуудаас хийгээд явдаг, бас алтныхаа үзэсгэлэнг хийдэг. Үнэт treasure гэж нэрлэгддэг үнэт зүйлсийн үзэсгэлэнгээ олон улсын Төв банкнууд гарга дагаад явдаг. Энэ яг л олон улсын жишгийн дагуу л бид бүхэн хийгээд явж байгаа. Мэдээж зардалтай холбоотой асуудал дээр бид бүхэн бодолцдог.

Зоосны хувьд франчайз зоос гэдэг маань захиалагч байгууллага нь өөрсдөө саналаа ирүүлдэг. Алтан зоос хийлгэх юм уу, мөнгөн зоос хийлгэх юм уу, зоосоо алтаар бүрүүлэх юм уу, мөнгөөр бүрүүлэх юм уу гэдгээ өөрсдөө хэлдэг учраас манай зүгээс бол тэдгээр байгууллагуудыг төлөөлөөд зоосыг нь тэдэн ширхэг хийлгэнэ энэ тэр гэж оруулж ирэхэд хүндрэлтэй байдаг.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын, асуулт, үг хамт явчихсан байгаа. Хэлсэн, хэлсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийг баримтлан боловсруулсан Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэлийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ Сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Тогтоолын төсөл дээр асуулттай гишүүд байна уу? Саналтай гишүүд байна уу? Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд л угаасаа хууль тогтоомжийн дагуу хийгддэг зүйл байх шиг байна. Яах вэ зүгээр би энэ талын мэдээлэл их хомс юм. Өчигдөр Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүд нэр дэвшиж байгаа хүмүүс энэ асуудлыг хөндөж ярьж байсан юм. Цаашдаа Улсын Их Хурал анхаарах, хууль, эрх зүйн орчныг нь сайжруулах шаардлагатай л гэж ярьж байсан.

Нөгөөтээгүүр нэг нэр дэвшигч хэвлэл мэдээллийн хэрэгслээр янз бүрийн юм явахад Монголбанк өөрөө яг бүрэн хэмжээний няцаалт өгч чадахгүй нь энэ Монголбанканд итгэх итгэл эргэлзээг төрүүлдэг гэж зүгээр ярианы завсартаа дурдаж байсан энэ зүйлийг хэлж байгаа юм. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр зарим хүн томилогдоод, дүүгээ төрийн албанаас гар гээд хэлж байхад зарим нь яг томилогдоод буухдаа ингээд хүн томилж байсан юм байна. Тэр дундаа бүр өөрөө жоохон үнэт зүйл цуглуулдаг, хамаарал бүхий этгээд нь үнэт зүйл цуглуулагч, музей ажиллуулдаг ийм хүнтэй ингээд хамаарал бүхий этгээдүүд ингээд Монгол Улсын эрдэнэсийн сангийн захирал гээд явж байх юм.

Тэгэхдээ би яах вэ таныг хувь хүн талаасаа буруудахгүй байна. Ингэж хэл амтай ингэж байхаар уг нь байгууллага дотроо арай жоохон зохимжтой яг мэргэжлээрээ ажил хийчхэж болдоггүй юм уу л гэдэг зүйлээс байгаа. Тэгэхээр энийг чинь ингээд явж байгаа мэдээллийг чинь хэн нэг нэр дэвшигч хүртэл барьж орж ирж яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлээсээ уг нь хувь хүн талаасаа ч гэсэн бодолцоод, дотроо ингээд шилжье барья гээд өргөдөл энэ тэрээ өгөөд шийдчихэж болдоггүй юм уу л гэсэн санаагаас хэлж байгаа шүү. Би тэрнээс биш хэн нэг этгээдийг зөв, буруу гэж хэлэх гээд байгаа юм биш. Ийм мэдээлэл яваад байхад хэн нэг нь дорвитой няцаалт өгөхгүй байхад иргэд чинь гайхаад байгаа байхгүй юу. Тэгээд л нэг Монголбанкны Хяналтын зөвлөлд орж ирж байгаа хүмүүс иймэрхүү өнгө аястай юм яриад байдаг. Тэгэхээр ийм зүйл гаргахгүй байхад л хэдүүлээ анхааръя.

2 дугаарт Энхтайван Ерөнхийлөгчийн нэг санааг жоохон хүртээмжтэй байлгах талаас анхаараач. Энэ эрдэнэсийн сангийн цуглуулга, энэ үнэт зүйлүүдийг иргэд, олон нийтэд таниулах, ялангуяа яах вэ энд хадгалагдаж байгаа түүх, соёлын үнэт зүйлүүдийг залуу үедээ, хүүхдүүд багачуудад таниулах ийм зүйлүүд дээр нэг жоохон Монголбанк холбогдох тэр музей энэ тэртэй нь аюулгүй байдал энэ тэрээ хангаад нэг жоохон хүртээмжтэй байдлаар явахад анхаараач. Соёлын яам энэ тэртэйгээ.

Би тэр алтны ийм үзэсгэлэн энэ тэр гардаг гээд сонсож байсан. Тэгэхдээ яг иргэд, олон нийт нэг их олноороо үзээд ч юм уу, янз бүр болж байсныг би сайн мэдэхгүй байна. Тэгэхээр яах вэ та нэгэнт л энэ хууль нь тийм юм, зорилго нь тэр юм чинь нэг жоохон олон нийтийн ялангуяа тэр соёлын бүтээлч үйл ажиллагаатай уялдуулаад иргэд соёл, эргээд Монгол Улсын сан хөмрөгт байгаа энэ чинь ард түмний л өмч гэсэн үг шүү дээ. Ямар өмч хөрөнгүүдийг бид цуглуулаад, хадгалж байдаг юм, ямар ач холбогдолтой байдаг юм ч гэдэг юм уу энэ зэргээс нь анхаарахад жоохон идэвхтэй ажиллаач л гэж хүсэж байна. Баярлалаа. Тэгээд тогтоолын төслийг дэмжиж байна шүү.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүнд баярлалаа. Өөр саналтай гишүүд алга байна. Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын

тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна.

18.59 цаг

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны бус гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан

Хэлэлцэх асуудал 2. СЗХ-ны дарга, орон тооны бус гишүүн, СЗХ-ны хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлын дарга Дашцэвэгийн Амарбаясгалан танилцуулна. Их Хурлын даргын микрофоныг нээе.

Д.Амарбаясгалан: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ оройн амар мэндийг хүргэе. СЗХ-ны даргад нэр дэвшигч Жамбаажамцын танилцуулгыг хийе. СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт хорооны даргад Улсын Их Хурлын дарга нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно гэж заасныг үндэслэн Түндэвийн Жамбаажамцыг СЗХ-ны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Жамбаажамц нь 1982 онд Баянхонгор аймгийн Баянхонгор сумд төрсөн. Ам бүл 6, эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2006 онд эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2017 онд СЭЗИС-ийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр тус тус төгсжээ. Жамбаажамц нь СЗХ-нд 2006 оноос эхлэн мэргэжилтнээр эхлэн ажиллаж тус байгууллагад нийтдээ 16 жил ажилласан байна. Тодруулбал 2006-аас 2007 онд СЗХ-ны Хяналт шалгалтын газрын мэргэжилтэн, 2007-гоос 2009 онд СЗХ-ны Үнэт цаасны газарт мэргэжилтэн, 2009-өөс 2011 онд СЗХ-ны Үнэт цаасны газарт хянан шалгагч, 2011-ээс 2013 онд СЗХ-ны Үнэт цаасны газарт ахлах хянан шалгагч, 2013-аас 14 онд СЗХ-ны Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, 2014-өөс 15 онд СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, 2015-аас 16 онд СЗХ-ны Хяналт шалгалтын газрын орлогч дарга, 2016 оноос одоог хүртэл СЗХ-ны Ажлын албаны даргын албан тушаалыг эрхэлсэн ажлын туршлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгосон төрийн захиргааны тэргүүн зэрэг дэвтэй, төрийн мэргэшсэн албан хаагч юм. Нэр дэвшигчийн мэргэшсэн байдлын хувьд Япон, Англи, Малайз, БНЭУ, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, БНСУ, БНХАУ, АНУ зэрэгт санхүүгийн хөрөнгийн зах зээлийн чиглэлээр богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан. 2010-аас 12 онуудад тодорхой хугацаагаар Нью-Йорк хөрөнгийн бирж, Лондоны хөрөнгийн

бирж, Хонг Конгын хөрөнгийн бирж, АНУ-ын хөрөнгө оруулалтын банк, Үнэт цаасны хороонд дадлагажигчаар суралцсан гэж байна. 2011 онд БНСУ-ын хөрөнгө оруулалтын банк болох “Leading Investment & Securities LLC-д 3 сарын хугацаанд дадлагажигч ажилтнаар тус тус мэргэжил дээшлүүлсэн байна.

Мөн хөрөнгийн зах зээл, компанийн засаглал, бизнесийн эрх зүй сэдвээр санхүүгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд эрх олгох болон мэргэшүүлэх сургалт, түүнчлэн СЭЗИС-ийн магистрын хөтөлбөрт 10 гаруй жилийн хугацаанд ажиллаж байна. Жамбаажамцын санхүүгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн байдал, мэдлэг боловсрол, СЗХ-ны төсөв, санхүү, хүний нөөцийн удирдлага, Монгол Улсын даатгал, бичил санхүү, хөрөнгийн зах зээл зэрэг санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалт, хяналтын орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан туршлага, удирдлага, зохион байгуулах чадвар, энэ байгууллагадаа тасралтгүй, тогтвортой, бүх түвшинд буюу гүйцэтгэх, удирдах албан тушаалд ажилласан байдлыг харгалзан төрийн албаны чадавхын зарчимд үндэслэн Улсын Их Хурлын даргын зүгээс СЗХ-ны даргад нэрийг нь дэвшүүлж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Өөрийн биеэр хүрэлцэн ирж танилцуулсан Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан танд баярлалаа. СЗХ-ны дарга, орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайлан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэг, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэг, 129, 130, 131, 132 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйл, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 27³ дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулж, дараах ажиллагааг явууллаа.

1.Хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилуулахаар санал ирүүлсэн болон Эдийн засгийн байнгын хорооноос зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн СЗХ-ны даргад Түндэвийн Жамбаажамц, орон тооны бус гишүүнд Булганы Саруул, Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн нарыг, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн даргад Мягмарсүрэнгийн Буяндэлгэр, гишүүнд Оюунтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр нарыг, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан нарыг, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад Нинжбатын Ууганбаатарыг, гишүүнд Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн Тэлмэн, Тунсагийн Тэлмэн, Данзанбалжирын Энхжаргал, Ундраагийн Хосжаргал, Гомбын Эрдэнэбаяр нарыг, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд Төмөрбаатарын Гарамжүгдэр, Дорждэрэмийн Цолмон, Ганболдын Золбоо, Идэшийн Батхүү, Дамдиндоржийн Мягмарцэрэн, Авирмэдийн Даваасүрэн нарыг нэр дэвшүүлсэн.

2.Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 3 дугаар тогтоолоор баталсан СЗХ-ны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт, ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу нэр дэвшигчид нь материалаа бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн болно.

3.Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддоржийг томилсон.

4.Сонсгол бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны хуудаст байршуулсан. Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, UBN.mn, ulsturch.mn, с.mn. soronznews.mn, shogch.mn, МҮОНТ, МҮОНР, ТВ 25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн. Сонсгол явуулах тухай зар мэдээллийн дагуу иргэн Б.Ганбаяр сонсголд оролцож, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчдээс асуулт асуух тухай хүсэлт ирүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо оролцогчийн хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж баталгаажуулсан.

5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт зааснаар Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр сонсголын ирц бүрдэх бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг, Да.Цогтбаатар, С.Эрдэнэбат нарын гишүүд оролцлоо.

6.Сонсголд оролцогч иргэн Б.Ганбаяр сонсголын үеэр СЗХ-ны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч М.Буяндэлгэр, гишүүнд нэр дэвшигч О.Оч, Б.Энхбаяр нараас асуулт асууж, хариулт авсан болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана гэж заасны дагуу сонсголд оролцсон гишүүд 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг гаргах хуралдааны үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх СЗХ-ны даргад нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамц, СЗХ-ны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Булганы Саруул, Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Оюунтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар, Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн Тэлмэн, Тунсагийн Тэлмэн, Данзанбалжирын Энхжаргал, Ундраагийн Хосжаргал, Гомбын Эрдэнэбаяр, ҮСХ-ны Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Идэшийн Батхүү, Төмөрбаатарын Гарамжүгдэр, Авирмэдийн Даваасүрэн, Ганболдын Золбоо, Дамдиндоржийн Мягмарцэрэн, Дорждэрэмийн Цолмон нарыг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн болно.

Нэр дэвшигчийн сонсголын тайлан гаргах хуралдаанд оролцсон гишүүдийн олонх СЗХ-ны хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзэж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

СЗХ-ны дарга, орон тооны бус гишүүн, СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, ҮСХ-ны Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн сонсголын тайланг хэлэлцэж өгнө үү. Анхаарал хандуулсан та бүхэндээ баярлалаа. Нэр дэвшигчийн нэр дэвшүүлэх эрх бүхий албан тушаалтны санал, нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Тийм, тайлан нэг гарсан учраас бүгдийг нь зэрэг гэсэн үг. Техникийнхэн энэ гишүүдийн төхөөрөмж болохгүй байна гэж байна. Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Ерөнхийдөө хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаад, эдгээр албан тушаалтнуудыг нийтэд нээлттэй байдлаар ярилцах, ямар байр суурьтай, ямар мэргэжилтэй, ямар туршлагатай хүмүүс дэвшиж байгаа гэдгийг олон нийтэд таниулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хийсэн. Би тэгээд яах вэ зүгээр зарим нэр дэвшигчид үнэхээр сайн бэлдэж орж ирсэн байсан гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Ялангуяа залуучууд энэ чиглэлдээ бэлдэж орж ирсэн ажлын туршлагатай зарим хүмүүсийг ч би хэлмээр байна. Олон хүнийг нэр зааж хэлэхэд төвөгтэй юм. Би тэгээд өчигдөр хэлэх үгээ хэлж байсан. Аливаа зүйлд иргэд, олон нийтэд энэ Улсын Их Хурлын үйл ажиллагаа буюу тэр дундаа томилгооны үйл ажиллагаа дээр нь ийм итгэл хүлээхүйц хүмүүс орж ирж байгаа гэдэг зүйл дээр хувийн бэлтгэлээ хангаж, асуулт, хариултад оновчтой хариулах энэ чиглэлдээ бэлтгэлтэй орж ирсэн хүмүүстээ талархаж байгаа.

Тэгээд 2, 3 хүмүүсээс ч би байр суурийг нь асууж байсан. Яах вэ зүгээр нэг зүйл байна. Малчны хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай хууль энэ тэрийг хийсэн хүн жишээ нь мөнгөний бодлого дээр очиж байгаа. Яг энэ зүйл дээр ярьж байсан хүн мөнгөний бодлого дээр очоод, энэ төсөв эргээд мөнгөний бодлогын энэ алдаатай бодлого буюу энэ төсвийн тэлэлтийг хийж байгаа энэ бодлого дээр хатуу байр суурьтай байна гээд

өчигдөр илэрхийлж байсан. Би нэр дэвшигчдээ асуултыг протоколд үлдэг гээд асууж байгаа шүү. Энэ хуулиар жишээ нь зүв зүгээр шимтгэлээ төлөөд явж байсан залуучууд 37 тэрбум төгрөгийг малчдын өмнөөс төлөхөөр болж байгаа. Та өөрөө очоод мөнгөний бодлого дээр ийм үйл ажиллагаанууд дэмжээд явах юм шив биз дээ? Малчдын зээлийг тэглэх асуудлыг нэр бүхий гишүүд яриад байгаа санаачилна гээд. Ийм зүйлүүд дээр дэмжээд авах юм биш биз дээ?

Би тэгэхээр таны ярьж байсан зүйлүүд энэний эсрэг байж чадна, зарчимтай байж чадна гээд та сонсгол дээр хэлж байсан шигээ энэ Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр хэлж өгөөч. Тэгээд яг бусад дээр нь би адилхан зарчим тавьж байгаа шүү. Тийм учраас нэр дэвшигч би Даваадоржоос асууж байгаа. Тэгээд та яг өчигдөр хариулж байсан шигээ малчдын зээлийг тэглэх, эргээд энэ малчдын НДШ-ийг нөхөн төлүүлнэ гэсэн ийм хуулиуд дээр өөрөө оролцоод явж байсан. Тэгэхдээ яг энэ дээрээ бичиж ирэхдээ эд нарыгаа шүүмжилчихсэн байсан байхгүй юу. Ийм алдаатай шийдвэрүүдээс болж төсвийн тэлэлт явагдаж байна, ингэж байна, тэгж байна гээд. Тэгэхээр яг энэ ярьж байсан зарчим дээрээ байж чадна биз дээ? Би бусад нэр дэвшигчдийг өөрөө өөртөө яг энэ асуултыг нэг асуучхаасай. Тэгэхдээ хариулах шаардлагагүй. Би зүгээр нэг хүнээс нь нэр заагаад асуучихъя. Тэгээд протоколд үлдэг. Тэгээд ингэж байж бид хэд хаана хаанаа зөв ойлголттой, энэ ярьж хэлж байгаа, бичиж байгаа зүйлүүд дээрээ эргэлзээгүй байх тал дээр анхаарна биз ээ гэж бодож байгаа юм. Зарим нэр дэвшигчид анхаарна биз. Урьдаас таачихсан юм шиг, төлөвлөчихсөн юм шиг орж ирдэг. Ингэнэ, тэгнэ гэж орж ирдэг. Өөрөөс нь бичсэн юмнаас нь асуухаар би наадхыг чинь яах вэ дээ.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут авах уу? Тэлье Сайнзориг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Дотроос нь өөрийн чинь бичиж, Улсын Их Хурлын нээлттэй сонсголд өгсөн материал дээрээс хүүхдээрээ бичүүлчихсэн, охиноороо бичүүлчихсэн. Эргээд би наадхыг чинь нэг тэгсхийгээд биччихсэн юм гэдэг хариултуудыг битгий өгч байгаарай. Энэ их муухай харагдаж байсан гэдэг зүйлийг би хэлье. Тэгээд сонгогдвол үгүй ээ томилогдвол та бүгддээ амжилт хүсье. Өөр надад асуух зүйл алга байна. Асуултыг байгууллага байгууллагаар нь багцлаад явуулъя. Ингээд нэгэнт тийм даргын асуудал 1 дүгээрт нь. Хариулт, асуулт тодорхой, хариулах хүн нь тодорхой учраас 4 номер.

Р.Даваадорж: Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороонд хүрэлцэн ирсэн гишүүдийнхээ гишүүддээ оройн мэндийг хүргэе. Надаас асуусан асуултад хариулъя. Миний бие 3 дахь парламентдаа ажиллаж байна. Эдийн засгийн ухааны доктор, судалгааны чиглэлээр ажилладаг. 80 орчим нийтлэл, эдийн засаг, мөнгөний бодлого, төсвийн бодлогоор өдөр тутмын сонин сэтгүүл, сайтад гаргасан ийм хүн байгаа. Надаас тэр малчдын зээлийг тэглэх асуудлаар 3 дахиа асууж байна Их Хурлын гишүүн маань. Би хариулъя, бас дахиад хариулъя. Би миний хэрвээ бичсэн нийтлэлүүд, миний нийтэд соён гэгээрүүлэх чиглэлд бичдэг эдийн засгийн миний үзэл бодлыг хэрвээ харах юм бол та надаас ийм асуулт асуухгүй байх байсан байх гэж би бодож байна.

Энэ хууль дээр би оролцоогүй. Би 20 орчим хууль бичсэн. Энэнээс 6, 7 хууль нь батлагдаад ингээд явж байгаа. Гэхдээ би малчдын зээлийг тэглэх хуулийг би бичээгүй, энд ерөөсөө оролцоогүй гэдгээ би хэлж байна. Яагаад гэхээр миний үзэл бодол энэний эсрэг юм. Татвар төлөгчдийн мөнгийг хэн нэгэн бүлэг улсуудад

сонгуулийн санал авах зориулалтаар өгдөг ийм зүйлийн эсрэг би нийтлэл битгий хэл сошиал бүх юугаар эсэргүүцэж ингэж бичиж явдаг хүний нэг байгаа юм. Тийм учраас та хэрвээ намайг ийм зүйлийг хийнэ гэж бодож байгаа бол би энэ нийт гишүүдийн өмнө хэлэхэд ийм асуудал гарахгүй гэдгийг давтан хэлэхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Баярлалаа. Хэдүүлээ ингээд багцлаад явна. Асуулт, санал, асуулт 2 хамт явж байгаа. Зөвхөн СЗХ-ны дарга дээр асуулт, санал явж байна. Тус тусад нь явахаар боллоо. Мөнхсоёл гишүүн яг энэ даргаас асуух гэж байна уу эсвэл дараагийн орон тооны бус гишүүн эд дээр асуух гэж байна уу? Даргаас асуух гэж байгаа бол одоо асууж болно. Тэгвэл Шижир гишүүн, Шижир гишүүн. Өлзийхүүгийн Шижир гишүүн даргаас асууна.

Ө.Шижир: Оройн мэнд. Асуулт, үг гэсэн учраас би үг хэлнэ. Ер нь сүүлийн хэдэн жилүүдэд төрд итгэх итгэл буурлаа гээд ингээд маш их ярьдаг, иргэдийн бухимдал энэ дээр маш их байдаг. Түүний шалтгаан нь юу вэ гэхээр Улсын Их Хурлын дарга ахтай эсвэл Улсын Их Хурлын гишүүн ахтай эсвэл сайд ахтай эсвэл төрд өндөр албан тушаал хашдаг хамаатан садантай хүмүүс иргэдийн боломжийг буюу боловсролын зээлийн санг түрүүлж авдаг, ЖДҮ-лэлийг дэмжих сангаас түрүүлж зээл авдаг, бизнесийн хөнгөлөлттэй зээлүүдэд түрүүлж авдаг, томилгоонд түрүүлж очдог, дарга цэрэг болдог ийм асуудлууд өөрсдөө нийгмийн маш их бухимдлыг бүрдүүлсэн л дээ.

Тийм учраас Ашиг сонирхлын тухай хууль гэж орсон. Тийм учраас Нийтийн албаны тухай хууль гэж орсон. Тийм учраас хэд хэдэн хуулиудад заалт оруулаад явж байсан. Ер нь жирийн боломж жирийн залуучуудад жирийн иргэдэд олдоггүй боломж заавал дарга цэрэг нарын, сайд нарын, эсвэл Их Хурлын гишүүдийн хүүхэд, эд нарын ах дүү нарт олддог болчихсон. Энэ нийгмийг бид болих ёстой юм. Энд байгаа маш олон Их Хурлын гишүүд бүгдээрээ яг энийг л ярьж орж ирсэн шүү дээ хэрээс хэтрээд байна гээд. Тэгээд өөрөө даатгалын бизнестэй мөртөө даатгалыг зохицуулдаг СЗХ-ны орон тооны бус гишүүнээр хамаатнаа тавина гэдэг чинь ямар утгатай юм бэ энэ чинь? Энэ чинь өөрөө Улсын Их Хурлыг маш муухай харагдуулж байгаа байхгүй юу. Би хувь хүний асуудал яриагүй шүү Сонороо би зарчим ярьж байгаа шүү.

Өөрөө даатгалын бизнестэй мөртөө даатгалын асуудлыг хариуцдаг СЗХ-нд өөрийнхөө хамаатныг тавьж байж болохгүй. Ийм зарчмын бид эсрэг байх ёстой. Дахиад энд байгаа 20 хэдэн хүний анкетаас нийтдээ 8 ямар нэгэн байдлаар ББСБ-тай хамааралтай байна. Энэ ашиг сонирхлын зөрчлийг энэ ажлын алба Эдийн засгийн байнгын хороо шалгаж үзсэн юм уу, үзээгүй юм уу гэдэг нэг асуудал байна.

Ер нь бид ингээд цаашдаа, цаашид цаашдаа төрд итгэх итгэлийг бий болгох, илүү мэргэжлийн хүмүүс томилох ийм заалтуудыг бид илүү болгохгүй бол одоо ингээд өөрсдийн ах дүү, хамаатан садныг томилдог ийм асуудал дахиад л эргэж орж ирж байна л даа. Та хэд санаж байгаа бол Боловсролын зээлийн сангийн асуудал анх сөхөгдөхөд Төсвийн байнгын хорооны Даваасүрэн манай 2 хүүхэд хоёулаа онц сурдаг юм, яагаад 200 мянган долларын зээл авч болдоггүй юм гээд даналзаад зогсож байсан. Би төлөхгүй гээд, тэгсэн биз дээ. Тэгтэл одоо яг ингээд Шадар сайд нь өөрийнхөө хамаарал бүхий бизнесийн салбарт хамаарал бүхий хүнээ томилуулж байгаа байхгүй юу. Ийм зарчмууд энэ цааш цаашдаа байж болохгүй. Энэ чинь хувь хүний асуудал яриагүй шүү.

Бусад энэ жишээ нь СЗХ-н дээр 4 хүн байна, 2 нь даатгалын бизнестэй хамааралтай шүү дээ. Монголбанкны юун дээр 3 нь даатгалын бизнес даатгал болон банк бустай хамааралтай байна шүү дээ. Тэгээд бид ямар хараат бодлого явуулах юм. Даатгалын компаниуд, банк бусууд өөрсдийнхөө төлөөллийг тавьж байгаа юм уу? Би тэгж л бодож байна. Тэгээд энэ дээр яах юм эргэж хараад энэ ажлын алба энэ анкетуудыг нь шүүж үзэх хэрэгтэй шүү дээ. Бүгдээрээ ашиг сонирхлын зөрчилгүй гээд ингээд мэдүүлчихсэн ийм байж болохгүй л дээ.

Р.Сэддорж: Ашиг сонирхлын зөрчлийг өөрсдөөр нь гаргуулаад, Авлигатай тэмцэх газарт явуулсан байгаа. Ажлын алба энийг эрхлэх хийхгүй учраас холбогдох газар луу нь явуулчихсан байгаа. Дараагийн СЗХ-ны дарга дээр асуулт асууж, үг хэлж дууслаа.

СЗХ-ны орон тооны бус гишүүдэд нэр дэвшигчдээс асуулт асуух, үг хэлэх гишүүд? Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Оройн мэнд хүргэе. Өчигдөр 13 цагийн турш энэ нэр дэвшигчид хүмүүсээс асуулт асууж, хариулт авч сонсгол хийсэн. Нэмж асуух зүйл алга. Тэгээд үг хэлье гэж бодож байна. Өнөөдөр манай Их Хурлын зарим гишүүд сошиалаар сая таны мэт асуудлыг хөндсөн. Түүн дээр хувь хүнтэй холбоотой асуудал гарсан учраас нэг талдаа мэдээж бид бүгдээрээ мэдэж байгаа аливаа ажилд очиж байгаа хүмүүс меритээ хангах ёстой, ур чадвар тодорхой шаардаж байгаа мэдлэг туршлагатай байх ёстой. Нөгөө талдаа энэ нөгөө эрх мэдэлтэй ч гэдэг юм уу, өндөр албан тушаал хашиж байгаа аливаа мэдээлэлд ойр хүмүүсийн ах дүү, хамаатан садан эргээд энэ төрийн албанд томилогдоход зарчмын асуудал хөндөгдөх ёстой гэж байгаа.

Гэхдээ энэ Сонор гээд нэр нь нэгэнт дурдагдлаа л даа. Тухайлбал энэ залуу Сангийн яаманд хангалттай олон жил ажиллачихсан, Монгол Улсынхаа нэр нүүр болоод олон улсын түвшинд бонд босгох болон бусад ийм маш нарийн мэргэшил шаардсан экспертиз шаардсан ийм ажилд ажилладаг энэ залуугаа боловсон хүчнийхээ энэ нөөц баялаг, мэдлэг туршлагыг ашиглахгүй байх нь эргээд манай Монгол Улсын энэ санхүүгийн зах зээлийн хөгжил дэвшилд хор хохиролтой юм болов уу гэж хараад байгаа юм. Тэгэхээр аливаа зүйлд хэтэрхий ерөнхийлж хандах нь буруу болчихоод байна. Тухайн хувь хүнийх нь өөрийнх нь өгөгдөл, намтар, туршлага мэдлэгийг харж үзэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлмээр байна. Би нөгөө өнцгийг хөндмөөр байна. Сонорын хувьд тэр хүний хамаатан садан болж төрсөндөө хувь хүнийхээ карьерыг хаях ёстой болох вий гэх юм уу, эсвэл Монгол Улсын энэ салбарт ашиглаж болох энэ ур чадварыг орхигдуулах ёстой болох юм уу гэх мэт яривал олон юм ярьж болохоор болчихоод байна. Ингээд хаяа.

Бусад нийт хүмүүст хамаатай асуудлыг хөндлөө. Тэрнээс зарчмыг ойлгож байна. Тухайн албан тушаалд чадвартай нь очих ёстой. Нэг юм мартагч гээд байна. Энэ СЗХ-ны орон тооны бус энэ гишүүнд Сангийн яамнаас тухайн газрын хэлтсийн дарга нь томилогдоод очдог ийм квотынхоо дагуу ирчихсэн юм байна лээ. Өөрөө хүсэлт гаргаагүй гэж ойлгосон. Баярлалаа.

Р.Сэддорж: Санал гэж ойлголоо. Санал хураалт явуулна. СЗХ-ны даргаар Түндэвийн Жамбаажамцыг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал

хураалт явуулъя. Гишүүд байраа эзлээрэй. Нэг нэгээр нь явах юм. Нэр гарахгүй зөвхөн хувь нь гарна, зөвхөн хувь гарна. Туршилтын санал хураалт, туршилтын нууц санал хураалт. Ингэж хуваарь гарна.

Санал хураалт явуулъя. СЗХ-ны даргаар Түндэвийн Жамбаажамцыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72,2 хувиар санал дэмжигдлээ. Протоколд болсон уу?

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дэмбэрэлдашийн Баярсайханыг СЗХ-ны даргын үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. СЗХ-ны даргыг томилж, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэг заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.СЗХ-ны даргаар Түндэвийн Жамбаажамцыг томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул СЗХ-ны даргын үүрэгт ажлаас Дэмбэрэлдашийн Баярсайханыг чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Энэ чуулганаар орно. СЗХ-ны даргад нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн гишүүн танилцуулах уу? Гишүүд саналаараа? Мандхай гишүүн, Мэндбаярын Мандхай гишүүн уншиж танилцуулна. Алдаржавхлан гишүүн горимын санал.

Ж.Алдаржавхлан: Энэ цаашдаа хувь хүний асуудлууд яригдах учраас нэг шүүж байгаа юм шиг олны өмнө шүүж байгаа юм шиг бөөнөөр нь хэлэлцмээргүй байна. Тэгээд мэдээж хүний асуудлууд байгаа учраас нэг нэгээр нь ингэж оруулж ирээд хурдан, хурдан хэлэлцээд явчихвал яасан юм бэ гэж. Тийм горимын санал гаргаж байна. Тэгээд олон бүгдээрээ сонсоод л байх чинь эвгүй шүү дээ тийм биз дээ. Тийм учраас хэдүүлээ энэ горимын саналыг та бүгдийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Бүх юм нээлттэй явж байгаа. Хаалттай юм ерөөсөө байхгүй байгаа. Ил нээлттэй явж байгаа. Энэ дээр санал хураалтгүй шууд ингээд шийдчихье биз дээ? Багц багцаар нь. Гишүүдийн олонхын саналаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүмүүсээ багц багцаар нь оруулж ирье. Жамбаажамц гарч байж болно.

СЗХ-ны орон тооны бус гишүүнээр нэр дэвшиж байгаа хүмүүсийг үлдэхийг урьж байна. Бүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ анкет хүмүүсийн анкет ил тод байгаа. Энд нууц ерөөсөө юм байхгүй байгаа гэдгийг хэлье. Дараагийн нэр дэвшигчийн сонсголын тайлан. СЗХ-ны орон тооны бус гишүүнээр Булганы, СЗХ-

ны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчдээс асуулт асуух асуулт асууж, үг хэлэх гишүүд саналаа өгье? Алга байна. Нэг нэгээр нь санал хураана.

СЗХ-ны орон тооны бус гишүүнээр Булганы Саруулыг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 77,8 хувийн саналаар дэмжлээ.

4.СЗХ-ны орон тооны бус гишүүнээр Лувсандоржийн Сонорыг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.СЗХ-ны орон тооны бус гишүүнээр Шагдаржавын Хандсүрэнг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

СЗХ-ны орон тооны бус гишүүн Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарын бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан СЗХ-ны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдэж чөлөөллөө. Тогтоолын, санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. СЗХ-ны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Санхүүгийн зохих зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Лувсандоржийн Сонор, Шагдаржавын Хандсүрэн, Булганы Саруул нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул СЗХ-ны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас Баасанжавын Батхишиг, Нямдэлэгийн Мандуул, Баярсайханы Баярдаваа нарыг тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. СЗХ-ны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл уншиж танилцуулна.

Дараагийн нэр дэвшигчийн сонсголын тайлан. Дараагийн хүмүүсээ оруулаарай. СЗХ-ны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Алга байна.

СЗХ-ны Хяналтын зөвлөлийн даргаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

СЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүнээр Оюунтөгсийн Очийг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

СЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүнээр Болдбаатарын Энхбаярыг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга Равсалын Ринчинбазар, гишүүн Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам нарын бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан СЗХ-ны хяналтын зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Мандхай гишүүнийх ажиллахгүй байна уу тийм ээ? Минийх бас ажиллахгүй байна. Протоколд дэмжсэнээр, дэмжсэнээр үү? Би байхгүй шүү дээ. Дараагийн юугаа уншуулна. Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох тухай, томилох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.СЗХ-ны Хяналтын зөвлөлийн даргаар Мягмарсүрэнгийн Буяндэлгэрийг, Хяналтын зөвлөлийн гишүүнээр Оюунтөгсийн Оч, Болдбаатарын Энхбаяр нарыг тус тус томилсугай.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар, 2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул СЗХ-ны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Равсалын Ринчинбазарыг, Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам нарыг тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. СЗХ-ны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн уншиж танилцуулна.

Дараагийн нэр дэвшигчийн сонсголын тайлан. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Жуковын Алдаржавхлан гишүүнээр тасалъя. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн. Жуковын Алдаржавхлан гишүүн. Ингээд Алдаржавхлан гишүүнийг хасъя. Санал хураалт явуулъя.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Намсрайн Батнасанг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Раднаасэдийн Даваадоржийг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Батбаатарын Мөнхзаяаг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Бямбажавын Энх-Амгаланг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн Цэрэндоржийн Батсүх, Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарын бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг томилох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 27³.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тогтоох нь:

1.Монгол Банкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр Намсрайн Батнасан, Раднаасэдийн Даваадорж, Батбаатарын Мөнхзаяа, Бямбажавын Энх-Амгалан нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас Цэрэндоржийн Батсүх, Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг уншиж танилцуулна.

Дараагийн нэр дэвшигчдийг оруулья. Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Мөнгөний бодлогын хяналтын зөвлөлийн гишүүд, Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүдийг бид ерөнхийдөө дэмжиж байгаа. Гэхдээ хяналтын зөвлөлийн дарга болж байгаа хүнд захиас хэлнэ. Та математикт их мундаг эрдэмтэн гэсэн. Тэгээд Монголбанкны хяналтын хорооны дарга болоод арилжааны банкнуудтай харилцаж ажиллана. Хяналт шалгалтын ажлуудад оролцох байх, дотоод хяналтыг хийх байх. Гэхдээ та зан харилцааны хувьд өөрийнхөө энэ хэт бардам зангаа барьж ажиллаарай гэж би танд нэг захиас хэлэх гэсэн юм. Та магадгүй том эрдэмтэн байх, мундаг эрдэмтэн байх, алдах юмгүй ч хүн байх. Гэхдээ та нэгэнт төрийн ажил авч байгаа бол энэ зан харилцаа, бусадтай харьцаж байгаа харилцаа, энд суугаа бүх хүмүүс өөрийн чинь шавь биш,

тааралдсан хүн болгон чинь өөрийн чинь шавь биш. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаасай л гэж би танд нөхөрсөг тийм зөвлөгөө өгөх гэсэн юм. Тэгээд энийг хүлээж авна байх гэж найдаж байна. Дотроо нэг тунгааж үзээд төрийн их том албан тушаал авах гэж байгаа хүн байна. Эгэл жирийн иргэдтэй энгийн сайхан харилцаж яваарай гэж хэлье дээ. Өөр хэлэх зүйл алга аа.

Р.Сэддорж: Үг хэлсэн гэж ойлголоо. Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Би үг хэлье. Харилцаа хандлагын асуудал анхаараад сайжруулаад явчхаж болох байх. Гэхдээ миний хувьд болохоор энэ Монголбанкны үйл ажиллагааг ил тод байлгаж, ялангуяа энэ эдийн засгийг урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хэн нэгний хараанд автчихгүй бие даасан, төрийн албанд ажиллаагүй энэ эрүүл тогтолцоогоо эсрэгээрээ урт хугацаанд хадгалаад, яг хяналтын энэ зөвлөлийн дарга яг тусгай бие даасан байдлыг урт хугацаанд хангаж ажиллаасай гэж бодож байна. Таны чадварт ерөөсөө эргэлзэхгүй байгаа. Харин ч шинэлэг, цоо шинэ саналуудыг илүү ийм үндэслэлтэй, онолтой, эрдэм шинжилгээний ийм ур чадвартайгаар гаргана гэдэгт эргэлзэхгүй байгаа. Харилцаа хандлагыг засаад явах боломжтой. Тэгэхээр ер нь амжилт хүсье гэж хэлье.

Р.Сэддорж: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Нэр дэвшиж байгаа хүмүүст амжилт хүсье. Монголбанкны хяналтын зөвлөл гэдэг чухал ажил байх. Монголбанкийг хүмүүс гадна талаас нь их харж янз бүрээр дүгнэж байгаа. Их олон дарга нарын эхнэр, хүүхдүүд, хамаатан саднууд байдаг юм гэнэ лээ. Тэгээд та бүхэн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдож очиж ажиллаад энэ асуудлыг ил тод гаргаж тавиарай. Үнэхээр тэр олон дарга нарын эхнэр, хүүхэд, хамаатан садан, найз амрагууд байдаг юм уу? Тэрийг ил гаргаж тавиарай гэж зориуд захиж хэлье.

Тэр үйл ажиллагаатай холбоотой асуудлууд яригдаад байдаг юм байна лээ. Тэрийг та бүхэн анхаарч ажиллаарай. Тэр үйл ажиллагааны ил тод байдал, дотоод хяналтын асуудал, бусдад, ялангуяа банкнаас бусад арилжааны банкнуудаас хамааралтай байдал гээд, улс төрчдөөс хамааралтай байдал гээд энэ асуудлуудыг анхаарч ажиллаарай гэдгийг зориуд захиж хэлье.

3 дахь юм нь тэр Монголбанкны нэлээн нөлөө бүхий хүмүүс нь энэ бол хэвлэл мэдээлэл дээр гарсан бөгөөд яригдаж байсан асуудлыг би хэлж байгаа шүү. Нэлээд нь ББСБ-д хувь эзэмшдэг, хувьдаа ББСБ-тай байдаг гэж мэдээлэгддэг. Энэ асуудал дээр нягталж, хэрэв тийм юм байгаа энэ зохимжгүй байх гэж бодож байгаа. Тэгээд энийг та бүхэн хэрэгжүүлж ажиллаарай гэж захъя. Тэгээд сая та бүхний өмнө Монголбанкны асуудал орж ирсэн. Түүн дээр зарим хүмүүсийн нэр ус дурдагдаж байна лээ. Тэгээд энэ дээр анхааралтай хууль барьж, зарчим барьж ажиллаарай. Тийм учраас та бүхнийг тал бүрээс ажил мэргэжил, эрдэм боловсрол, туршлагыг харж нэр дэвшүүлсэн байх гэж бодож байна. Тэгээд өчигдөр бүхий л ил тод, нээлттэй явж байгаа шүү дээ энэ сонгон шалгаруулалт, хэлэлцүүлэг, сонсгол гээд бүх зүйл. Ямар нэгэн хуваагдал талцалгүй ажиллана гэдгийг ахалж ажиллах гэж байгаа хүн хэлж байна лээ. Энэ нэг талдаа сайн хэрэг. Тэгээд түрүүний хэлж байгаа ил тод байдлыг анхаарч ажиллах ёстой.

Сая гишүүдийн хэлж байгаачлан тэр харилцааны асуудлыг яалт ч үгүй анхаарах ёстой асуудал энэ. Монголбанк гэдэг маш чухал байгууллага. Дахиад тодруулаад хэлэхэд бид гадна талаас нь Их Хурлын гишүүд хүртэл зарим зүйл дээр нь сайн ойлголт байхгүй, оролцоо байхгүй. Нэг захирал нь орж ирж жоохон томорч байгаад л гараад явчих жишээний ийм байгууллага байх жишээний. Ер нь Их Хурлын энэ 126 гишүүнтэй парламентаас сонгогдож байгаа, томилогдож байгаа Хяналтын зөвлөлийн гишүүдийн хувьд энэ ил тод ажиллаасай л гэж хүсэж байна. Энийг их эрхэмлээсэй, энийг бодитой хийгээсэй. Саяын яригдаад байгаа асуудлуудыг анхаарч ажиллаарай. Эдийн засгийн байнгын хороо та бүхэнтэй уялдаж ажиллах байх. Гишүүний хувьд би энийг та бүхнээс нэхэж ажиллана. Тодорхой хугацааны дараа яг энэ асуудлаар би та бүхнээс асуулга авна. Бүгдэд нь амжилт хүсье.

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа та бүхэндээ хандаж хэлэх зүйл байна. Монголын ард түмнийг төлөөлж тэдний өмнөөс хяналт тавих энэ үүргээ Их Хурал биелүүлж, тэгээд та бүхнийг иргэдийн өмнөөс хяналт тавихаар ингэж илгээх асуудлыг хэлэлцэж байгаа. Тэгэхээр би нэг зүйлийг л захиж хэлэх гэсэн юм. Монгол Улс ийм чөлөөт зах зээлийн эдийн засагтай. Иргэдийн юу худалдаж авах, авахгүйг заах нь тийм зохимжгүй байгаа гэж би хувьдаа бодож байгаа. Тэгээд энэ үүднээсээ жишээлбэл Монголбанк шийдвэр гаргаад иргэдийн хэрэглээний тэр дундаа автомашин худалдан авах энэ зээлийг арилжааны банкнуудаас олгохыг хориглосон шийдвэр гаргасан юм байна. Тэгээд үүнтэй уялдаад иргэд автомашины хэрэгцээ бүгдээрээ байгаа. Хэдийгээр импортын балансыг тэнцвэржүүлэх ийм бодлогыг барьж байгаа хэдий ч иргэдийг автомашин авах, авахгүйг ингэж хязгаарлах нь тийм тохиромжтой биш.

Тийм учраас Монголбанк ийм шийдвэр гаргачихсан учраас арилжааны банкнуудаас хэрэглээний зээл автомашины зээл гарахгүй учраас банк бусаас хүмүүс тэртээ тэргүй л автомашины хэрэгцээ байгаа учраас ингээд банк бусын зээлээр авч байгаа. Тэгээд энэ хүүгийн зөрөө нэлээд их байгаа. Өөрөөр хэлбэл банк бусын зээлийн хүү өндөр учраас иргэдэд очиж байгаа дарамт нь их хэмжээгээр нэмэгдэж байгаа шүү дээ. Тэгээд хүүгийн энэ зөрөө их байна гэдэг чинь иргэдийн зарлага нэмэгдэж, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа л ийм зүйл. Өөрөөр хэлбэл мөнгө хүүлэгчид гэж хэлж болох энэ банк бус санхүүгийн байгууллагууд энэ автомашины зах зээл дээр худалдан авах зах зээл дээр нь их хэмжээний ийм орлого олж байгаа ийм л дүн баланс гарч байгаа шүү дээ.

Тийм учраас энэ зүйлийг та бүхэн жилийн эцэст Монголбанкны энэ аудит, дүн шинжилгээнд хяналт хийхдээ энэ зүйлийг нэг бодож, ард түмний өмнөөс ийм судалгаа хийж яг энэ нь зөв шийдвэр юм уу, Монголбанкны энэ хязгаарлалт тавьсан нь буруу юм уу, зөв юм уу гэдгийг тунгааж, тэгээд энэ Их Хуралд ажлаа тайлагнах үедээ энийг ард иргэдэд мэдээлж өгөөсэй л гэж хүсэж байна. Мэдээж тухайн хуулиар оногдсон эрх байгаа, үүрэг байгаа. Гэхдээ эцсийн дүндээ та бүхэн нэг л зүйлийг ойлгох хэрэгтэй. Энэ иргэдийн өмнөөс тэнд Монголбанкны үйл ажиллагаанд хяналт тавихаар очиж байгаа гэдгээ л ойлгох хэрэгтэй. Тийм учраас энэ Төв банкны хуульд заасан энэ эрх, үүргийн шийдвэрийн үрээр, үр дүнгээр иргэдэд ямар хэмжээний ачаалал очсон, энэ нь зөв байсан уу, буруу байсан уу гэдгийг асар том судалгааны үндсэн дээр хийх хэрэгтэй. Зарим иргэд хардаж

байгаа банк бус санхүүгийн байгууллагуудын ард ямар нэгэн лобби байна, даатгалын байгууллагууд.../минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар санал хураалт явуулна.

Хяналтын зөвлөлийн даргаар Нинжбатын Ууганбаатарыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Сугарын Лхагвадоржийг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 72,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Гэрэлтийн Тэлмэнг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Тунсагийн Тэлмэнг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 88,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Ундраагийн Хосжаргалыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Данзанбалжирын Энхжаргалыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Гомбын Эрдэнэбаярыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Далрайн Даваасамбуу, гишүүн Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарын бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилж, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.3} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар Нинжбатын Ууганбаатарыг, Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр Сугарын Лхагвадорж, Гэрэлтийн

Тэлмэн, Данзанбалжирын Энхжаргал, Ундраагийн Хосжаргал, Тунсагийн Тэлмэн, Гомбын Эрдэнэбаяр нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Далрайн Даваасамбууг, Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Лхагвадоржийн Ариунаа, Лувсан-Очирын Дондог, Баатаржавын Лхагважав, Бат-Очирын Цэрэнбалтав, Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Мишигийн Энх-Амгалан нарыг тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Монгол банкны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл уншиж танилцуулна.

Дараагийн нэр дэвшигчийн сонголын тайлан. ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдэд орж ирж байна. Нэр дэвшигчдээс асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Статистикийн дүн мэдээ олон шийдвэр гаргалтад ашиглагддаг ийм чухал зүйл байгаа. Тэгээд яах вэ амьдрал дээр орон нутагт гэхэд жишээлбэл сумдад статистикийн ажилтан гэж орон тооных байхгүй ингээд хавсран гүйцэтгүүлдэг. Тэгээд энийг хариуцлагатай ажилладаг болгох хамгийн чухал шаардлагатай байгаа. Яагаад гэхээр бүх зүйл анхан шатнаас энэ мэдээ нь ирдэг. Жишээлбэл би нэг жишээ хэлж өгье. Үхрийн гоц халдварт өвчин гарахад тэр үхрийн тухайн тэр өвчлөл гарахаас өмнөх сарынх нь статистик үнэлгээгээр нөхөн олговрыг эндээс 90 хувиар тооцож өгдөг ийм зохицуулалттай байхгүй юу.

Гэтэл тэр статистикийн үнэлгээг тэр тухайн сардаа өгөөгүй, яг бодит байдал дээр үндэслэж өгөөгүй байх юм бол энэний хор хохирол нь ард иргэдэд ирнэ. Тэгэхээр ийм статистикийн мэдээлэл ийм чухал байдаг учраас Улсын Их Хурлын дэргэд Улсын Их Хурлаас томилдог ийм байгууллага байдаг гэж бодож байгаа. Тийм учраас энэ зүйл дээр онцгой анхаарч, сумын түвшинд, багийн түвшинд, аймгийн түвшинд, нийслэл, дүүргийн түвшинд энэ мэдээллийг үнэн зөв байх зүйлийг онцгой анхаарах хэрэгтэй 1.

2-т нь жишээлбэл ийм түүх байгаа. Орон сууцын тоо гээд авангуут орон сууцад амьдардаг өрхийн тоог өгөх байтал орон сууцын барилгын тоог өгчхөж байгаа юм. Тэгэхээр статистик дүн мэдээ ингээд өөр гардаг. Тэгэхээр энэ зүйлүүдийг онцгой анхаарч ингэж ажиллах тал дээр миний хэлж байгаа санал нь ийм орон нутгийн энэ салбар анхан шатны нэгжүүд дээр энэ мэдээ гаргалт дээр байнгын сургалт семинар хийж, ажлын байрны шалгуурт нь орж, цаашдаа нэмэлт энэ ажлыг гүйцэтгэж байгаа бол хавсран гүйцэтгэж байгаа бол энэний ажлынх нь үнэлгээ үнэлэмжийг нь яаж тооцох юм гэдгийг их бодож явах ийм шаардлага анхан, дунд шатад байгаа шүү. Тэгээд энэ дээр онцгой анхаарч ажиллаж өгөөрэй гэдгийг хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Статистикийн байгууллагын хорооны зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж байгаа та бүхэндээ амжилт хүсье. Тэгээд статистикийн байгууллагын оролцоо бүтээгдэхүүний үнэн зөв байдал бол энэ улс орны хөгжил дэвшилтэй

салшгүй холбоотой. Тэгээд манай орны хувьд нэлээн энэ статистикийн байгууллагын ажил үйлс нэлээн өндөр түвшинд явдаг, дэлхий нийтэд тэгж үнэлэгддэг. Та бүхэн маань ингэж шинээр энэ албан тушаалуудад томилогдохоор нэр дэвшээд явж байгаа. Тэгээд өөр өөрсдийн бодолтой явж байгаа байх. Тэгээд улам энэ ажлыг сайжруулж, улам хэрэглэгчид, ард иргэд, мөн олон улсын байгууллагууд энэ улсуудад хүртээмжтэй, мэдээллийг хүртээмжтэй байлгах тал дээр нь илүү анхаарч, шинэ томилогдох магадлалтай хүмүүс учраас шинэ арга барилаар байгууллагынхаа хүмүүст шинэ эрч хүч өгсөн ийм ажил үйлсийг санаачлан хийхийг хүсье. Асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт. ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Идэшийн Батхүүг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Босоод танилцуулчих хэрэгтэй. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Төмөрбаатарын Гарамжүгдэрийг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Авирмэдийн Даваасүрэнг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Ганболдын Золбоог томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Техникийн, Мандхай гишүүний энэ аппаратыг техникийнхэн анхаараарай. 77,8 хувийн саналаар дэмжиж байна. Дэмжигдлээ.

28.ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Дамдиндоржийн Мягмарцэрэнг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Дорждэрэмийн Цолмонг томилуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. ҮСХ-ны зөвлөлийн гишүүнийг томилох тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.ҮСХ-ны зөвлөлийн гишүүнээр Дамдиндоржийн Мягмарцэрэн, Идэшийн Батхүү, Дорждэрэмийн Цолмон, Ганболдын Золбоо, Авирмэдийн Даваасүрэн, Төмөрбаатарын Гарамжүгдэр нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. ҮСХ-ны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр

дэвшигчийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан уншиж танилцуулна. Унших юм уу? Аль нь унших юм бэ? Энэ тогтоолыг Улсын Их Хуралд Пүрэвжавын Сайнзориг гишүүн уншиж танилцуулна.

Гурав.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Тувааныг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Сайдын микрофоныг нээе, 5 номер.

Ц.Туваан: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ, та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын ажил, тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн биржийн арилжаа, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаар та бүхэнд мэдээллийг хүргэе.

Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлын тухай. Геологийн салбар нь өөрөө том цогц салбар бөгөөд төрөл бүрийн масштабтай зураглал, эрэл, үнэлгээ, хайгуул, геофизик, геохими, гидрогеологи, гео экологи, геоморфологи зэрэг олон салбар шинжлэх ухааныг багтаадаг. Алсын хараа 20 50 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ гэж заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй геологийн судалгаа. Геологийн судалгааны ажлын үр дүнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд болон бүс нутаг тодорхой газар нутгийн нийгэм, эдийн засгийн байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, хөгжлийн нэгдсэн төлөвлөлт хийх, хөгжлийн стратегийг боловсруулах суурь мэдээлэл бий болдгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 1-ийг харьцах 50 мянганы геологийн зураглал ерөнхий эрлийн ажил 46,9 хувьтай, улсын геологийн 1-ийг харьцах 200 мянганы иж бүрэн зураг зохиох ажил 100 хувьтай, тус зургийг нэгтгэх ажил 14 хувь, геохимийн нэгийг харьцах сая масштабын зураг зохиох ажил 100 хувь, агаарын геофизикийн нэгийг харьцах 200000-ын соронзон судалгааны ажилд 70 хувийг хамруулаад байна.

Ашигт малтмалын эрлийн чиглэлээр үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний төслүүдийг хэрэгжүүлж дууссан. Эдгээр судалгааны ажлын үр дүнд 25 төрлийн 126 илэрц, 9 ордыг тогтоон илрүүлсэн баялгийн хэмжээг тооцсон. Монголын өнгөт болон үнэт металлын хүдэржилт байх өндөр

магадлалтай талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааг сүүлийн үеийн аргачлалаар түүний үр дүн, үнэмшил, нарийвчлалыг нэмэгдүүлэх зорилгоор 202 мянган км квадрат нутагт гүйцэтгэж байна.

Тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж буй хайгуулын ажлын талаар. Хайгуулын ажил нь ашигт малтмалын орд буюу эдийн засгийн үр ашигтай нөөцийг эрэх, хайх, үнэлэх, тооцоолох гэсэн геологийн судалгааны нэг үе шатын ажил юм. Хувийн хэвшлээс хайгуулын ажилд 2016 онд 192,5 тэрбум төгрөг зарцуулж байсан бол, 2021 онд 102,5 тэрбум төгрөг болж буурсан. Геологи хайгуулын салбарыг олборлох, боловсруулах салбараас түрүүлүүлэн хөгжүүлэх стратегийг баримтлан эрдэс баялгийн найдвартай нөөцөөр хангах зорилгоор хөрөнгө оруулалтыг татах, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд төрөөс тогтоосон талбайд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох арга хэмжээг хэрэгжүүлснээр 2022 онд 168,8 тэрбум төгрөгийг хайгуулын ажилд зарцуулсан байна. Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд 2014-өөс 23 онд зэсийн нөөц 32,1 мянган тонноор, алтны нөөц 488,6 тонноор, төмрийн нөөц 630,9 сая тонн, хайлуур жоншны нөөц 38,8 сая тонноор тус тус нэмэгдсэн.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын тухай. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулиар хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр, 1997 оноос иргэн болон хуулийн этгээдэд өргөдлөөр, 2006 оноос сонгон шалгаруулалт болон өргөдлөөр, 2014 оноос өргөдөл болон сонгон шалгаруулалтаар, 2017 оны өөрчлөлтөөр зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар төрөөс тогтоосон талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохоор болсон. 2010 онд Тусгай зөвшөөрөл олгохыг хориглох тухай хууль батлагдан 2010-аас 14 онуудад хайгуулын тусгай зөвшөөрөл олгоогүй.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хуульд тусгасан. Уг өөрчлөлтийн дагуу сонгон шалгаруулалтын журмыг баталж, тус журмаар 2024 оны 4 дүгээр сар хүртэл тусгай зөвшөөрөл олгосон байна. 2024 оны байдлаар Монгол Улсын Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 74 хувьд ашигт малтмалын хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах боломжгүй хориглогдсон байдаг бол Монгол Улсын ЗГ 2018 онд 8,4 сая га, 2023 онд 8,6 сая га талбай нийтдээ 17 сая га талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж талбай солилцсоныг баталсан. 2024 оны 12 сарын 16-ны өдрийн байдлаар нийт 2726 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаагийн хайгуулын 981, ашиглалтын 1632 тусгай зөвшөөрөл хүчинтэй байна. Энэ нь нийт газар нутгийн нутаг дэвсгэрийн 4,38 хувийг эзэлж байна. 2018-аас 24 онд буюу 7 жилийн хугацаанд 533 хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож, улсын төсөвт 177 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааны тухай. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2022 оны 12 сарын 23-ны өдөр баталсан бөгөөд 23 оны 6 сарын 30-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Хууль хэрэгжиж эхэлснээр Монголын хөрөнгийн бирж ХК-аар дамжуулан 2023 онд 14,9 сая тонн нүүрс, 604,8 мянган тонн төмрийн баяжмал арилжиж нийт 2,1 сая ам.долларын, 2,1 тэрбум ам.долларын борлуулалтын орлого, үнийн өсөлтөөс хамаарч 155,3 сая ам.долларын нэмэлт орлого олсон бол 2024 онд 859 удаагийн арилжаагаар нийт 36,7 сая тонн нүүрс, 2,9 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал,

17,6 мянган тонн хайлуур жонш, 6 мянган тонн зэсийн баяжмал арилжиж, 16,26 их наяд төгрөгийн орлогыг тус тус олсон байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн явцын тухай. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалт үндсэн 4 багцаас бүрдэх ба эдгээр ажлууд нь ЕРС нэг багцын 11 барилга байгууламж, ус дамжуулах системийн барилга угсралтын ажил дуусаж, улсын комисст шат дараатайгаар хүлээлгэн өгсөн. ЕРС 2 багцын инженер геотехник суурь судалгааны ажлыг дуусган, ажлын нарийвчилсан зургийн ажлыг эхлүүлж, 2024 оны 23 оны 4 дүгээр сард барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Багцад багтсан байгууламжийн ажлын нарийвчилсан зургийг Испани улсын Интеска Индастриал компани гүйцэтгэж байгаа. Зарим зураг төслийг боловсруулж дууссан байна. Атмосферийн болон вакум нэрлэгийн цамхаг зэрэг 20 орчим тоног төхөөрөмжүүдийг АНУ, Франц, Энэтхэг, Австрали зэрэг улсуудад үйлдвэрлэж эхлээд байна.

ЕРС 3 буюу ДЦС-ын уурын зуухыг Их Британийн, турбин генераторыг Германы компаниудад захиалж эдгээр тоног төөрөмжүүдийг үйлдвэрлэж эхлээд байна. Мөн тус багцын ерөнхий гүйцэтгэгчээр Мега Инженеринг компани 160 гаруй зураг төслийг боловсруулан ажиллаж байна. ЕРС 4 багц ажилд хамрах лицензтэй технологийн байгууламжийн лиценз эзэмшигчээр шалгарсан Францын Аксенс, Италийн Кинетикс технолож, АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл, Шотландын Шелл компаниуд өөр өөрсдийн байгууламжийн зураг төслийг боловсруулж 2023 онд дуусгасан. Ерөнхий гүйцэтгэгч Мега Инженеринг компани ЕРС 4 багц ажлын гэрээг батлагдсан зээлийн дүнд багтаан багц ажлын 1 дүгээр хэсгийн гэрээг байгуулсан ба нэмэлт санхүүжилт шийдвэрлэгдсэний дараа уг багцын 2 дугаар хэсгийн гэрээг байгуулна. ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан байна. Төслийн багц ажлуудын гүйцэтгэл 2024 оны 10 сар, 11 сарын 1-ний байдлаар ЕРС-1 100 хувь, ЕРС-2 23,8 хувь, ЕРС-3 17 хувь, ЕРС-4 8 хувийн гүйцэтгэлтэй ерөнхий дүнгээр 21,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх тухай. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.1.1-д байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж, үүнд татвар, ашиг, үр өгөөжийн дийлэнх буюу 50-аас дээш хувь нь Монголын ард түмэнд ноогдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах гэж заасан. Энэ хүрээнд ЗГ-ын өргөн мэдүүлснээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 сарын 19-ний өдөр баталсан.

Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар заасан байдаг. Тодруулбал Ирээдүй өв санд, Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд улсын төсөвт төвлөрсөн АМНАТ-өөс нэн тэргүүнд хуваарилж, үлдэх хэсгийн 65 хувийг нь, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашиглалт, боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэл хувьцаанд ноогдох ноогдол ашгийг төвлөрүүлэн газрын

хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх ерөнхий зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зааснаар 1 их наяд 849,7 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, 507,1 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр тусгасан болно. Мэдээллийг өгч дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Отгоншарын Батнайрамдал гишүүнээр тасалъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Уг нь их чухал мэдээлэл байдаг. Танхим жоохон цөөн тооны л байна. Тэгэхдээ яах вэ зүгээр энэ танилцуулгууд гишүүдэд цахим байдлаар хүргэгдэж байгаа учраас мэдээллүүдээ авах байх. Ер нь зүгээр эдийн засгийн бүтцээ авч үзвэл уул уурхайгаас хамааралтай байгаа эдийн засаг дээр яг энэ үйл ажиллагаануудыг дэмжсэн, тогтворжуулсан, эргээд хариуцлагатай уул уурхай, орж ирсэн энэ өгөөжийг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан тэр байгалийн баялаг үр өгөөжийг нийт ард түмэн хүртдэг байх, орон нутгийн иргэд түлхүү хүртдэг байх тэр бодлогыг л цаашдаа бүгд ярьдаг биш уг нь нэг баталгаажуулчихмаар байгаа юм.

Жоохон зарим зүйлүүд их яриад байна. Тэгээд яриад байхаар сүүлдээ нөгөө хүмүүст энэ сэдэв нь сүүлдээ чихэнд нь нэг тийм нэг л наалдаж очихоо ч больж байна. Эд нар байнгын л ингэж ярьдаг гэдэг зүйл байх шиг байна. Тэгээд би яах вэ нөгөө Туваан сайдын өгч байгаа мэдээллийн ар дээр Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна гэсэн хуулийнхаа жагсаалтыг оруулаад иржээ. Энэ дээр ингээд энэ, энэ хуулиудаа гээд зааж байгаад баяртай байна. Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга гэж байна. Тэгээд би яах вэ зүгээр энэ хууль, эрх зүйн талаасаа ашигт малтмалын хуулиа 2 салгачихвал яадаг юм бэ гэдэг энэ хууль зүйн техник талаас нь нэг бодооч.

1 дүгээрт Ашигт малтмалын хуулиа яг бие дааж гаргаад, геологийн хайгуул, судалгаанаасаа эхлээд, энэ мэдээллийн сангаа бүрдүүлэх, энэ ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хайгуулын болон олборлолтын зөвшөөрлүүдээ олгох энэ харилцаа, ямар үед нь түдгэлзүүлэх, эргээд энэ бараа, бүтээгдэхүүнийг биржээр зарах хуультайгаа тусгай зөвшөөрөл олгохтойгоо яаж олгох үедээ гэрээний нөхцөлөөр тохиролцож болох уу, үгүй юү гээд наад захын жоохон юмнуудаа яваад, энэ биржийн харилцаагаа ч гэсэн дэмжих бололцоог нь өгчихмөөр байгаа юм.

Эцэст нь байгаль орчны хууль тогтоомжтойгоо балансыг нь олоод хаалтын асуудал нь Ашигт малтмалын хуулиараа ингээд зохицуулагддаг баймаар байгаа юм. Энэ дээр нь төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх хэмжээний асуудлыг ч гэсэн маш тодорхой болгочихъё. Газрын хуультайгаа жоохон уялдуулчихъя. Ийм зүйлүүдийг оруулж ирээд Амнатийн бодлогоо татварын хуулиар явуулчихвал яадаг юм бэ гэдэг зүйлийг хэлээд байгаа юм. Ер нь зүгээр татварын асуудлыг татварын хуулиар зохицуулна гээд байгаа боловч өнөөдөр Монгол Улсын хэмжээнд энэ зарчим баригдахгүй байгаа ганцхан хууль асуудал ашигт малтмалын салбар. Сүүлдээ ингээд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь бодлогоо тодорхойлох биш, яах вэ зүгээр манай санхүү, төсвийн асуудал ч гэсэн төрийн

захиргааны байгууллага дээр энэ хуулийн чинь хэрэгжилт, энэ хуулийн чинь өөрчлөлт ерөнхийдөө төсөв дагаад л явчхаад байдаг ийм талууд байна. Тэгээд энэ дээр орж ирээд, Сангийн яамны тэр бодлого зөв байсан, буруу байсан, ингэсэн, тэгсэн гэдэг хэлэлцүүлгүүд нэлээн явдаг юм. Тийм учраас ингээд бодлогоо хууль, эрх зүйн талаасаа зааглаж салгаад, тэгэхдээ мэдээж уялдаатай явалгүй яах вэ. Энэ чиглэлдээ хууль зүйн техникээ анхаараач гэж хүсэж байгаа юм.

Байгаль дэлхийтэйгээ зөв харьцах, хариуцлагатай уул уурхайн хүрээнд энэ Газрын хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль, ялангуяа орон нутгийн тусгай хамгаалалтад авдаг ямар ч цензургүй нэг ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: Сайнзориг гишүүнд нэг минут.

П.Сайнзориг: Орон нутгийн тусгай хэрэгцээнд авчихдаг. Тэгээд энэ дээрээс ингээд төв ЗГ ч гэдэг юм уу тодорхой хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөд байдаг, тэнд очоод яг буцаад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагатайгаа үл ойлголцол ингээд үүсдэг ийм зүйл байна. Тэгэхээр энэ бүх зүйлүүд дээр эдийн засгийнхаа гол секторыг бодоод, хэдүүлээ нэг ЗГ л энийг хийнэ, Улсын Их Хурлын ажлын хэсэг дээр хийчихнэ гээд л нэг хэсэг Туваан сайд маань хариулаад байдаг байсан. Харин энэ удаад би өөрөө оруулж ирнэ гээд хэлж байгаад нь талархаж байгаа юм шүү. Тийм учраас та нэг зөв өнцөг, энийгээ Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, орон нутгуудтайгаа маш сайн яриад нэг ийм энэ тэнцвэрийг хангасан энэ зун нэг оруулж ирээч л гэдэг зүйлийг би ингээд хэлэх гээд байгаа юм.

Туваан сайдаа би танай баг хамт олон байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар орон нутаг төсөл хэрэгжүүлэгч компаниудтай гэрээ байгуулдаг, тусламж авдаг, дэмжлэг авдаг юм байгаа. Маш ил тод бус. Энэ орон нутгийн удирдлагуудыг зарим талаараа ч буруу зүйл.../минут дуусав/

Р.Сэддорж: Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Манай Монгол улс энэ уул уурхай хамааралтай, уул уурхайн орон хэдийн болсон. Нэгхэн тоо нь экспортын орлогын 93 хувийг уул уурхай дээр, уул уурхайгаас олж байгаа. Энэ сүүлийн үед манай Улсын Их Хурал, ЗГ-ын оруулж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж өгч байгаад талархал илэрхийлье.

Маш олон чухал асуудлуудыг хөндөж байна. Юу гэхлээр Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг Наранбаатар гишүүнээр ахлаад байгуулсан. Дээрээс нь Улсын Их Хурлын 126 гишүүнээс 28 гишүүн дэмжиж гарын үсэг зурсан. Уул уурхайг дэмжих лобби бүлгийнхэн гээд. Энэ 2 хэсэг хүмүүсийн төлөөлөл манай яаман дээр очиж ажиллаж байгаа. Тэгэхээр бид бүхэн яамнаасаа энэ ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх ажлын дэд хэсэг байгуулах хүмүүсээ бүх төлөөллийг хангаад оролцуулаад ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр бид бүхэн энэ асуудал дээр нэлээн тийм ултай суурьтай хандах, ялангуяа энэ Ашигт малтмалын тухай хууль анх 2005 онд батлагдсанаасаа хойш нийт зохицуулалтынх нь 70 гаруй хувьд нь ямар нэгэн байдлаар нэмэлт, өөрчлөлт ороод ингээд нэг тийм нэлээн тийм үхрийн бөөр шиг тийм хууль болчихоод байгаа.

Тэгэхээр зохицуулах харилцаа дээр нь хууль зохицуулна гэхээсээ илүү дагалдах журмуудаар зохицуулж байгаа харилцаанууд нэлээн орж ирж байгаа. Тэгэхээр энийг нэлээдгүй ярьж шийдвэрлэх ийм зайлшгүй шаардлага байгаа учраас бид энэ Их Хурлын ажлын хэсэгтэйгээ, дэмжих бүлэгтэйгээ маш нягт ойрхон хамтарч ажиллаж эдгээр таны саяын ярьсан асуултууд дээр, асуудлууд дээр ажиллана гэсэн ийм бодолтой эхний уулзалтуудаа бид яаман дээрээ хийгээд ингээд явж байгаа гэдгийг хэлье.

2 түвшинд авч үзэх асуудлыг бид ойлголоо, тэмдэглэж авлаа. Тэгээд ярилцъя. 1 дүгээр гол хэсэг дээрээ бид энэ бие даасан байдлаар энэ хуулиа авч үзээд, лицензийн, биржийн харилцаа, байгаль орчин, хаалтын гэрээ, орон нутаг, газрын харилцаатай асуудлуудаа оруулж ирэх гээд энэ л үндсэн манай хуулийн ноён нуруу. Тэгээд энэ Амнаттай холбоотой асуудлыг сүүлийн үед Улсын Их Хурлын гишүүд маш их ярьж байгаа. Ялангуяа Бадамсүрэн гишүүн нарын гишүүд энэ уул уурхайгаа ашиглая гэвэл Амнат, тэр дундаа энэ орон нутгийн иргэд, орон нутагт нь хэрхэн Амнатын менежментийг хийж, хуваарилах вэ гэдэг асуудлыг маш хурцаар олон удаа тавьж байгаа. Тэгэхээр энэ хуульдаа бид энийг зайлшгүй шийдэж өгөх асуудал гэж ингэж харж байгаа. Дэлхий нийтийн түвшинд ч гэсэн энэ ийм байдлаар асуудалд хандаж байгаа гэдгийг хэлье.

Амнат дээр бид янз бүрийн байдлаар шийдэх ийм боломж байгаа. Тэгэхээр Сангийн яамныхантай энэ асуудлыг нэлээн ярилцах, ялангуяа стратегийн ордын 34 хувь дээр хэлцэл хийх асуудал энэ тэр дээр хүртэл Ораногийн гэрээрхүү маягтай энэ асуудлуудыг барьж ажиллаж болох юм гэдэг ийм гаргалгаануудыг гаргаж байгаа. Хариуцлагатай уул уурхайн асуудлыг бүүр маш өндөр түвшинд авч үзэхгүй бол бүгд харилцан энд харилцаанд оролцогч бүх талууд харилцан ашигтай гэдэг ийм зүйл байхгүй бол уул уурхайн салбар цаашаа явахад нэлээн хүндрэлтэй байгаа гэдгийг хэлье. Орон нутгийн зүгээс бид яг л энэ хариуцлагатай уул уурхайнхаа хүрээг энэ кодексынхоо хүрээнд асуудлуудаа ярьж явж байж энэ нөгөө орон нутгийн иргэдтэй зөрчилдөх, Амнатаар тухайн уурхай ашиглуулж байгаа орон нутгийн иргэдийн эрх ашиг хангагдах.../минут дуусав/

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Та асуултдаа миний тодруулсны дараа нэмээд хариулчхаарай. Тэгээд энэ уул уурхай дахь ил тод байдлын зарчим буюу ер нь тэгэхдээ баланстай байх ёстой. Олборлох үйлдвэрийн ил тод байдлыг хангах санаачилгад бид ингээд орчихсон явж байдаг, бас хэтэрвэл хэцүү. Зарим талаараа энийгээ жоохон хангаад, уул уурхайгаас энэ орон нутагт ямар дэмжлэгүүдийг үзүүлээд байгаа асуудлыг энэ Орон нутгийн хөгжлийн санд өгч байгаа мөнгөнүүдийг уг нь энэ байгуулсан гэрээ энэ тэрийг ил тод тайлагнах хуультай юм Нийтийн мэдээллийн ил тодын. Энэ хангалтгүй байна. Энэ хангалтгүй байгаа болохоор иргэд, орон нутгийн иргэд ерөөсөө мэдээлэл байхгүй. Тэнд зөвхөн нэг орон нутгийн нутгийн өөрөө удирдах ёсны удирдлагад сонгогдсон хэдэн хүмүүс л захиран зарцуулдаг юм шиг байгаа юм. Тэгээд энэ зүйлүүдийг нэг ил тод болгоод, уул уурхайгаас орон нутагт ийм benefit-үүд байдаг юм. Тэгэхдээ энэ дээр нь бид шахаж ажиллана гээд уг нь иргэдээ жоохон мэдээлэлжүүлэх чиглэл дээрээ та хэд маань нэг жоохон дорвитойхон ажиллаач л гэж би хүсэж байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ бол аргагүй чухал асуудал. Тэгээд орон нутагт уул уурхайн компани очоод ажилладаг. Тэгээд энэ ажиллах дээрээ нийгмийн хариуцлагын гэрээ, мөн энэ ил тодын асуудлуудаа ч гэсэн ингээд яриад, тэгээд энэ дээр нэг санхүү мөнгөний асуудал яригддаг. Энэ мөнгөө аваад тэгээд зарцуулалтын тодорхойгүй байдал ингээд нэг иргэдэд очихгүй байх гэсэн ийм байдлууд байгаа. Тэгэхээр энэ нэлээн чухал асуудал. Энийг бид энэ хариуцлагатай уул уурхайн хүрээнд мөн энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийнхаа хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа. 18 дахь тайлангаа гаргаад ингээд явж байгаа гэдгийг танд хэлье. Энэ бол нэлээн цогцоор нь авч үзэх асуудал дотор орон нутагтай учраа ололцох, ард иргэдийн мэдээллээ шилэн байдлаар авах гэдэг асуудал дээр нэлээн чухлаар тавигдаад явна. Тэгээд энэ тал дээр тантай.../минут дуусав/

Р.Сэддорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Уул уурхайн салбар яалт ч байхгүй Монгол Улсын эдийн засагт, Монгол Улсын экспортын ихэнх хувийг хийж байгаа маш чухал салбар байгаад байгаа. Тэгэхээр Туваан сайд маань ажлаа аваад энэ аж үйлдвэр, эрдэс баялгийн салбараа ялангуяа энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань болохоор илүү бодлогоо барьдаг, геологийн алба болон Үндэсний геологийн алба болон Ашигт малтмал, газрын тосны газар нь болохоор хэрэгжүүлэгч агентлаг гэж ойлгоод байгаа. Тэгээд ингээд зөвхөн уул уурхайн салбараас илүүтэйгээр геологийн алба нь гэхэд олон салбарт хэрэгтэй зүйл хийх боломжтой ийм алба юм байна гэж хараад байгаа юм. Зөвхөн уул уурхайн салбар биш. Барилга байна, зам, тээвэр байна, ХАА байна. Сүүлийн үед энэ байгалийн гамшиг Монгол Улсад маш ихээр тохиолдож байна. Тийм учраас энэ хөрсний гадарга, энэ хөрсний гулгалт, үер ус болж байгаа энэ бүх байдал дээр энэ Үндэсний геологийн алба бол маш өндөр үүрэгтэй оролцох боломжтой юм байна гэж харж байгаа. Тийм учраас ҮГА-ыг ер нь цаашид бэхжүүлэх талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань ямар төлөвлөгөө гаргаж ажиллаж байна вэ гэж 1 дүгээр асуулт.

2 дугаарт ер нь бид цаашдаа өнөөдөр яах вэ бид Монгол Улс өмнө нь илрүүлсэн ордуудынхаа үр ашгаар эдийн засгаа нэлээн аваад явж байна. Цаашдаа бид олон ордуудыг нээж, илрүүлэх ёстой. Тэгэхээр энэ талаар юу хийж төлөвлөж байна вэ гэж асуулт байгаад байгаа юм. Тэгээд энэ АМГТГ-ын үйл ажиллагаануудыг сайжруулах талаар ер нь яамнаас ямар ажлууд төлөвлөж ажиллаж байгаа вэ гэдэг ийм асуулт байгаад байна. Яах вэ энэ тайлан дээрээс экспортын мэдээллийг харахаар жишээлбэл Дорнод аймагт Дашбалбар сумд Шинь шиний уурхай гэж байдаг полиметаллын орд. Энэ полиметаллын экспортын хэмжээ нь хэд байдаг юм бэ? Энэ талын мэдээлэл нь яг аль тайландаа орж харагддаг вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. ҮГА-д албад дэлхийд бүх энэ улсуудад ерөнхийдөө ихэнхэд нь байдаг. Ялангуяа уул уурхай түгээмэл хөгжсөн улсуудад байдаг ийм алба. тэгээд ер нь уул уурхайн салбарын ерөөсөө А үсэг анхдагч нь энэ геологийн салбар байдаг. Энд судалгаа шинжилгээгээ хийгээд, хаанаа ямар ашигт малтмалын илэрц, ямар нөөц байх вэ гэдэг зүйлүүдийн хамгийн анхдагч бүх судалгааг хийж байдаг А үсэг нь геологийн

салбар байдаг. Манай улсад энэ яг энэ байдлаараа хэрэгжиж чадахгүй байж байгаад ҮГА-тай болоод ингээд явж байгаа. Миний хувьд энэ салбарын сайдаар ЗГ-ын төлөөлөгчөөр томилогдож ирээд, ҮГА-ыг илүү томруулах, чадавхжуулах ажил дээр онцгой анхаарч, энэ ҮГА-ыг орон тооны хувьд гэхэд 30 орчим хүнтэй байдлаар биш, илүү томруулж байж илүү нэлээн том бүтэцтэй байж томоохон ажлыг ялангуяа энэ эхний нэгд эрэмбэлэгдэх ажлаа хийх юм гэдэг ийм бодлогыг баримталж ажлаа явуулсан.

Тэгээд харамсалтай нь мэдээж Монгол Улс парламентын засаглалтай орон учраас энэ ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, яамдын бүтэц бүдүүвчийн асуудал энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хэмжээнд байдаг учраас энэ дээр асуудлуудаа шийдвэрлүүлж чадаагүй. Тэгээд цаашдаа энэ асуудлыг тавиад явна гэж бодож байгаа. Мэдээж 1 дүгээрт геологи, 2 дугаарт нь ашиглалт олборлолт, тэгээд гуравдугаарт нь ингээд үйлдвэрлэл гэсэн ийм эрэмбийн дарааллаар явдаг. Тэгэхээр Геологийн албаа бид нэлээн ач холбогдол өгч ажиллана. Тэгээд харамсалтай нь энэ асуудал дээрээ бүрэн бодлогоо хэрэгжүүлж чадахгүй байгаа гэдгийг хэлье.

Цаашдаа бид дэлхийн уул уурхайн хөгжлөөр тэргүүлэгч орнуудын хувьд ялангуяа Канадад гэхэд геологийн судалгаа, хайгуул судалгааныхаа ажлыг тодорхой чиглэлүүд дээр 100 хувь гүйцэтгээд дууссан. Хаанаа ямар баялаг байгаага мэдэж байгаа. Уул уурхайн магнайт Австрали улс гэхэд газар нутгийнхаа 32,5 хувьд нь хайгуулын лиценз олгочихсон ингээд нэлээн судалгаа хийгээд явж байх жишээтэй. Тэгэхээр энэтэй харьцуулахад манай улс 3,2 хувь буюу ойролцоогоор 1000-аад лицензийг хайгуулын лицензтэй л сууж байгаа л ийм улс. Тэгэхээр бид судалгаа энэ салбарын асуудал нэлээн хязгаарлагдмал байгаа гэдгийг хэлье.

Харин сүүлийн үед ЗГ-аас өнгөрсөн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж байсан ЗГ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас эхлүүлсэн энэ алдсан цаг хугацааг нөхөх буюу маш дэлхийд хэрэглэдэг үр дүнтэй агаарын соронзон хайгуулын энэ хайгуул судалгаа дээр нэлээн төсөв тавиад явж байгаа. Энэ асуудлыг бид үргэлжлүүлэн нэлээн тавьж, улсын төсөв дээр энэ талын судалгааг нэлээн хийж байж, орчин үеийн уул уурхайн салбарт хэрэгтэй датануудыг, ашиглах боломжтой датануудыг цуглуулах гэдэг энэ тал руу нэлээн бодлогоо бариад явж байгаа гэдгийг хэлье.

Ашигт малтмалын, Ашигт малтмал, газрын тосны газар үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ дээр миний хувьд энэ ашигт малтмал гэдэг утгаараа биш, ер нь бид энэ жил яамныхаа нэрийг аж үйлдвэр талаа оруулаад, эрдэс баялгаа бид Минерал ресурс гэдэг тэр олон улсын байдал руу нэлээн оруулж явахаар яамныхаа нэршлийг өгсөн. Энэ дотроо ер нь үндсэндээ 2 тусдаа салбар буюу.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулья.

Ц.Туваан: Эрдэс баялгийн салбарынхаа асуудлыг ер нь олон улс нэлээд олон улсад тусдаа байдаг энэ эрдэс баялгийн асуудал, газрын тосны бүр шал ондоо гэдэг шиг энэ салбар 2 нэг агентлагт байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид тусад нь болгоод, бодлогоор нь ингээд аваад явъя гэдэг ийм бодлоготой явж байгаа. Тэгэхээр мэдээж энийг шийдэх газар нь Улсын Их Хурал дээр байгаа.

Газрын тосны салбар дээр бид өнөөдөр үндэсний өөрийн гэсэн газрын тос боловсруулах үйлдвэртэй болох ийм амбицтай явж байгаа. Дээрээс нь олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа. Ялангуяа Их Хурлын гишүүдийн санал болгож байгаа үндэсний олборлогч компаниудын асуудал ярьж байгаа тохиолдолд бид энэ бие даасан агентлагийн байдлаар аваад явах нь илүү үр дүнтэй гэсэн ийм бодол, алсын зорилготой явж байгаа гэдгийг хэлье. Манай газрын.../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер гүйцээж хариулъя. Хэдэн номер вэ? 4 номер.

С.Жавхланбаатар: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Шинь шинь компани хар тугалганы олборлолт явуулж экспортолдог байж байгаа. 24 оны статистик мэдээг өгье. 18 мянган тонн экспортолсон байна. Нийт дүн нь 61,1 сая ам.долларын урьдчилсан дүнгээрээ ийм статистик байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулъя. Бадамсүрэн гишүүнийг нэмье.

О.Соронзонболд: Туваан сайдаа нөгөө геологи, ҮГА-ыг зөвхөн уул уурхайн салбарт биш, эдийн засгийн бусад салбарууд нийгэм, эдийн засгийн бусад салбаруудад ашиглах тал дээр яг ямар чиглэл бодлого барьж байна вэ? Одоо бид чинь шинээр баахан хот байгуулж байна. Улаанбаатар хот маань байнга үерт автаж байна тийм ээ. Бусад аймгийн төвүүд дээр асуудлууд байдаг байх. Тэгээд хөдөө аж аж ахуй бусад салбаруудыг дэмжих талаар яг яаж ҮГА-ыг ашиглах вэ? Энэ тал дээр ер нь ямар бодлого барьж байна вэ гэж асуусан.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ чухал асуудал. Тэгээд манай дээр геологийн судалгаа гэхээр л яг нэг энэ эрдэс баялгийн ашигт малтмалын чиглэл рүүгээ л бодоод байдаг. Үйл ажиллагаа ч гэсэн энэ тал руугаа нэлээн яваад ирчихсэн. Тэгэхээр би энэ байгууллагыг ҮГА-ыг геологи, эрдэс баялгийн салбарын агентлаг болгоод, тэгээд дотроо бусад төрлийн ялангуяа таны саяын хэлсэн хөрсний судалгаа, мөн барилгын салбарын суурь судалгаа, газрын судалгаа, дээрээс нь манайд тусдаа агентлагаар явж байгаа энэ усны асуудал. Энэ усны асуудал чинь өөрөө гидрогеологи гээд маш чухал асуудал байгаа шүү дээ. Энэ асуудал энэ тэрийг судалсан байдлаар өргөжүүлээд явъя гэхээр яг өнөөдрийн байдалд нэг байгаа орон тоо нь 33 хүний орон тоотой ийм ҮГА гэсэн нэртэй байдлаар ингээд явуулчихсан, маш бага төсөвтэй л байгаа юм. Тэгээд энэ асуудлаа эргэж тавьж.../минут дуусав/

Р.Сэддорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Баярлалаа. Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Монгол Улсын эдийн засагт эрдэс баялгийн салбар ямар чухал ач холбогдолтойг бид нэлээн сайн ойлгодог болсон байх. Улсын төсвийн 1/3-ийг энэ салбар дангаараа бүрдүүлж байгаа. Ер нь олон улсад доллар оруулж ирэхийн тулд энэ өөрөө дэлхийн бусад оронтой тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өрсөлдөнө гэсэн үг юм. Тэгэхээр энэ одоогийн байдлаар Монгол Улсад хамгийн өрсөлдөх чадвар сайтай ер нь ганц салбар нь өөрөө уул уурхай байхгүй юу. Тэгэхээр энэ салбар Монгол улсыг 30 жил

тэжээж ирсэн, цаашаага ч 30 жил хамгийн том байр суурь эзэлсэн салбар байх болно.

Тэгэхээр энэ салбарыг өрсөлдөх давуу талтай цаашаа байлгана гэдэг нь дараа дараагийн Оюу толгой шиг ч юм уу, Тавантолгой шиг ч юм уу орд үүсэн бий болох тэрийг олох тэр боломжийг нь уул уурхайн салбар төрийн бодлогын зүгээсээ олгох ёстой юм. Тэгэхээр миний асуух гээд байгаа асуулт энэ таны илтгэл дээр байна л даа. Ерөөсөө ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт 2016 онд санагдаж байна, 2016 онд нэг үйл явдал болсон юм манай уул уурхайн салбарт. Энэ их тийм бахархаад байхаар үйл явдал биш л дээ 17 он юм байна. Энэ юу вэ гэхээрээ ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо хайгуулын тусгай зөвшөөрлийн тооноосоо багасаад явчихсан гэсэн үг, урвуу хамаарал гэсэн үг. Уг нь хайгуулын тусгай зөвшөөрөл нь ашиглалтын тусгай зөвшөөрлөөсөө хэд дахин илүү байх ёстой. Яагаад гэхээр яг практик дээрээ олон улсын жишгийг аваад үзсэн ч гэсэн магадгүй 100 хайгуулын лицензээс 1 ашиглалтын лиценз гарвал энэ нь аягүй сайн үзүүлэлт байхгүй юу.

Гэтэл 2017 оноос хойш энэ хамаарал урвуу явсаар байгаад яг таны илтгэл дээр байна л даа. 24 онд 1759 ашиглалтын лиценз, хайгуулын лиценз нь нэг ёсондоо 981 болоод буурчихсан гэсэн үг. Тэгэхээр ер нь бид улам л дараа дараагийн том ордууд олдох энэ боломжоо өөрсдөө хязгаарлаад байна гэсэн үг л юм л даа. Ер нь энэ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт гэдэг нь энэ процесс өөрөө ер нь маш их асуудал дагуулж ирсэн. Ер нь олон улсын Монгол Улсын тайлангууд дээр хамгийн ашиг сонирхол ихтэй, хамгийн асуудал ихтэй тод жишээгээр ингээд орж ирсэн байхгүй юу. 2021 онд санагдаж байна, 2021 онд тухайн үедээ миний хувьд дэд сайд байхдаа энэ сонгон шалгаруулалтын журмыг цахимжуулах гэж маш их эсэргүүцэлтэй тулгарч байсан. Тухайн үедээ бүр Сүхбаатарын талбай дээр зохион байгуулалттай малчдыг хүртэл авч ирж энэнийг зогсоох гэж оролдож байсан түүхтэй юм. Тэгэхээр энэ сонгон шалгаруулалтын журам хэр хэрэгжсэн юм бол? Энэ дээр биччихсэн байна л даа. 25 онд энэ сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн батлуулна гэж. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байгаа юм бол, дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч гэсэн.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Маш чухал салбар баярлалаа. Дараагийн Оюу толгой, Тавантолгойн асуудлыг мэдээж геологийн хайгуулыг хийж байж нээж илрүүлнэ. Тэгэхээр таны дараагийн асуултууд энэ рүү чиглэж байна. Бид жишээлбэл нэгхэн жишээ авъя. Дараагийн Оюу толгой гэхээр зэсийн орд. Бид өнөөдөр Монгол Улс дэлхий дээр зэсийн Амнатыг 19 хувьтай байгаа цөөхөн улсууд байдаг байх. Энэний нэг. Тэгэхээр 19 хувь, Эрдэнэт маань мэдээж ТӨК учраас энүүгээрээ төлөөд явж байгаа. Оюу толгой өнөөдөр 5 хувийн татварын тогтворжуулалтаараа 5 хувийн Амнат төлөөд явж байгаа.

Дараагийн Оюу толгой шиг компани орж ирэхийн тулд энэний зөрөө гэхэд л 14 хувийн зөрөө байгаа. Тэгэхээр бид энэ дээр хууль, эрх зүйнхээ асуудлыг шийдэж өгөхгүйгээр дараагийн Оюу толгойг ашиглалтад оруулна. Олж бол болно, ашиглалтад оруулна гэхэд нэлээн хүнд асуудал байгаа. Ашиглалтын лиценз, хайгуулын лицензээсээ даруй нэг дахин бага байгаа. Энэ бол бодитой үнэн. Энэ харамсалтай бол зүйл. Юу гэхээр бид хайгуулаа маш илүү түвшинд явуулж байж

энэ дундаас маш цөөхөн ашиглалтын лиценз гарч ирдэг. Энэ олон улсын практикт байгаа тоо.

Тэгэхээр бид энэ ашиглалтын, хайгуулын лиценз олгох асуудлаа бид нэлээн тийм шулуухан хэлэхэд улс төржсөн байдлаар сонгуулийн жилүүдийн өмнөх жилүүдэд энэ тэр хаагаад, олгохоо болиулж бариад ингээд ирсэн ийм асуудал байгаа. Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар хайгуулын лиценз олгох асуудал хаалттай байгаа. 2024 оны 12 сарын 30-ны байдлаар манай яаман дээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журмаа шинэчлэн батлаад, Хууль зүйн сайддаа сайд руу нийтээр дагаж мөрдөх журамд бүртгүүлэхээр хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар бүртгэгдэж ирээгүй байгаа. Тэгээд удахгүй бүртгэгдэж ирнэ байх гэж бодож байна. Тэгэхээр ер нь энэ хайгуулын тусгай зөвшөөрлийг бид олгож байж, энэ дээр энэ анхдагч байдлаар асуудлуудаа шийдэж байж, энэ салбарын дараагийн хөгжил ирнэ гэдэг таны энэ асуудалтай санал нэг байна.

ЗГ-ын түвшинд хайгуулын лиценз олголтын асуудал нэлээн маргаантай байдаг учраас энийг газрын лиценз олголттой адилхнаар буюу ЗГ дээр эцсийн шийдвэрийг нь албажуулж гаргаад явдаг байя гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр бид Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсэг Наранбаатар гишүүний ажлын хэсэг дээр ярьж хуульд өөрчлөлт оруулах байдлаар энэ асуудлаа шийдээд явна гэсэн байдалтайгаар явж байгаа. Тэгэхдээ ер нь олон улс болон Монголын уул уурхайн салбар дээр энэ лицензээ нээгээч гэдэг хүлээлт маш их байгаа. Тэгээд ЗГ дээрээс 25 оны 1 сарын 1-нээс нээнэ гэдэг амлалтыг өгөөд явсантайгаа холбогдуулаад энэ лицензээ журмаа батлаад Хууль зүйн яаманд хүргүүлсэн байгаа. Энэ дээр тэр сонгон шалгаруулалтын лиценз зарлахад шалгуур дээр нь мөнгөний шалгуурыг 70 хувь байсныг 60 хувь руу бууруулаад, тэгээд бусад техникийн шаардлагуудыг шалгуурт 40 хувь байхаар оруулаад ингээд ер нь хуучинтай нь нэлээн тийм төстэй байдлаар журмаа ингээд батлаад явж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэгэхээр энэ Монгол Улсын хамгийн өрсөлдөх давуу талтай дараагийн 30 жилдээ ч гэсэн хамгийн чухал салбар байх. Ер нь уул уурхайн салбарыг цаашаагаа урт хугацаандаа тогтвортой явуулахын тулд энэ хайгуулын лицензийн сонгон шалгаруулалт өөрөө явах ёстой юм л даа. Хэрвээ бид дахиад лиценз гаргах энэ боломжоо хаагаад байх юм бол тэгвэл уул уурхайн салбараа битгий хөгжөөсэй гэсэнтэй нэг агаар адилхан сонсогдож байгаа юм л даа 1 дүгээрт.

2 дугаарт энэний нэг сул тал нь энэ сонгон шалгаруулалт нь өөрөө дандаа асуудал дагуулж ирсэн байхгүй юу. Энд янз бүрийн асуудал байдаг байсан. Тухайн үедээ 120 хуудас document-ээс бүгд дээр нь гарын үсэг зураад, нэг гарын үсэггүй байх юм бол хүчингүй болгодог ийм л юм явж ирсэн шүү дээ. Тэгэхээр энийг онлайн буюу цахим хэлбэр лүү шилжүүлсэн тэр өөрчлөгдөөгүй биз дээ? Энэ сонгон шалгаруулалтын журмыг хэр сайжруулж оруулж ирсэн юм бол?

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Бид тэгэхээр хамтарсан ЗГ үйл ажиллагаа явуулаад хагас жил болж байна. Энэ дээр мэдээж энэ сонгон шалгаруулалтын журмын буюу хайгуулын лиценз олгох журмын асуудал хөгжүүлэлт нь нэлээн явж байгаа. ЗГ

дээр түрүүний хэлсэн байр суурин дээр байгаа. Тэгэхдээ бид тэрүүгээр шалтаглаад энэ сонгон шалгаруулалтыг олгохгүй, Х лиценз олгохгүй байх асуудлыг бол гаргуулах нь байх нь өөрөө улс орны эдийн засагт маш их хоцорчлоод байгаа энэ үйлдлийг дэмжсэн ийм байр суурь болох учраас одоохондоо яг тэр хуучин өмнө нь хэрэгжүүлээд олгоод явж байсан журамтай төстэй, мөнгөний шалгуурыг нь 10 хувиар бууруулсан. Тэгээд зарим компаниудын тендерт оролцсон байдлаас харахад нэлээн өндөр дүн өгөөд хаячхаад, тэр нь цаашаа гаргалгаа байхгүй зогсдог гэсэн энэ асуудлуудыг шийдсэн байдлаар оруулж ирж байгаа. Тэгээд энэ асуудлыг нэлээн журмын.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариултыг дахин тодруулж, хангалтгүй гэж үзэж байна. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Туваан сайдаа сонгон шалгаруулалтын журам дээрээ би танд өөрөө хувь хүний зүгээс ч гэсэн үнэхээр сайн ач холбогдол өгөөсэй гэж үнэхээр хүсмээр байгаа юм. Яагаад гэх юм бол энэ зөвхөн хэдхэн хүн биш, яг үнэнийг хэлэхэд энэ сонгон шалгаруулалтын журам сайжирч орж ирэх нь үү, үгүй юү гэдгийг бүхэл бүтэн салбар тэр чигээрээ гадаадын хөрөнгө оруулагчид, тэгээд олон нийтийн зүгээс ч гэсэн маш өндөр хүлээлт байгаа шүү. Тухайн үедээ энэ сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэх гэж бөөн юм болж, бид энийг цахим болгож байсан. Ингэснээрээ маш их ирдэг гомдлууд тэр чинээгээрээ бараг байхгүй болж байсан. Гэхдээ тэр 70, 30 гэсэн харьцаа 60, 40 гэж орж байна гэдэг чинь буцаад л хүнээс шалтгаалах тэр асуудлаа та улам л ихэсгэж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр тэрийг улам илүү нээлттэй болгох, тэрийг тэр 40 болгосон буцаад асуудал үүсгэх вий. Тэгэхээр энийгээ маш сайн тооцоолсон байгаасай л гэж хүсэж байгаа юм.

Р.Сэддорж: Хариулах уу? 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Таны зөвлөгөөг хүлээж авлаа. Тэгээд бид бүхэн нөгөө хуулиа хүлээгээд, журмаа бүүр төгөлдөр болгохыг хүлээхээр маш их цаг алдах гээд байгаа. Олон улсын I марк дээр гэхэд жишээлбэл, дээрээс нь бид minning week гээд арга хэмжээ дээр маш олон гаднынхан оролцсон эд дээр, дээрээс нь ЗГ-ын тэргүүн эд нар бүгдээрээ ойрын хугацаанд энэ асуудлаа шийднэ гэдэг амлалтыг энэ уул уурхайн салбарынхандаа, геологичдодоо, хувийн компаниуддаа, гаднын компаниудад өгсөн учраас энийг та яг бүр гэж битгий ойлгоорой. Ямар ч байсан энэ асуудлыг хуулиар зохицуултал буюу ирэх хаврын чуулганаар Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирээд, эцэслэн шийдэгдтэл ийм арга хэмжээг бид 25 оны 1 сарын 1-нээс хайгуулын лиценз олголтоо нэмнэ гэсэн амлалтдаа хүрч энэ асуудлыг шийдээд явж байгаа. Тэгээд цаашаа сайжруулалт нь хийгдээд явж байгаа гэж ойлгож.../минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүнийг нэмье. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Надад Байнгын хорооны даргад хандаж нэг санал байгаа. Манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний яамнуудын мэдээллийг аль болох ийм чанартай цөөн сонсоод, тэгээд бодлогын хэрэгжилтдээ илүү сайн төвлөрөх шаардлагатай байна 1.

2 дугаарт нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 6 дугаар зүйл, тэгээд баялгийн, Үндэсний баялгийн сангийн хууль гээд энэ сайн хуулиудыг Оюун-

Эрдэнийн ЗГ өргөн мэдүүлж, өмнөх парламент баталсан энэ бол маш чухал. Одоо хэрэгжилт чухал байгаа. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр ингээд анх Оюу толгойн гэрээ хийхэд ч тэр, Пунсалмаагийн Очирбат Ерөнхийлөгч тухайн үед газрын тосны талбайг нээхэд ч тэр их том үйл явдал болох нь гээд ард түмэнд, Монголын иргэдэд их том хүлээлт үүссэн. Тэгээд харамсалтай нь хэрэгжилтийнхээ шатад ингээд зөндөө асуудал гараад. Тэгээд энэ уул уурхайд итгэх итгэл үлэмж хэмжээгээр буураад байгаа л даа. Тийм учраас одоо яах вэ гэхээр энэ том бодлогуудын хэрэгжилт дээр бүх шатад анхаарч ажиллах ийм шаардлагатай байгаа.

Тэгээд стратегийн орд гээд ингээд хязгаарлачихсан. Тэгэхээр стратегийн орд гэхээс илүүтэй энэ стратегийн ашигт малтмал гэдэг энэ ангиллыг цаашдаа баримтлах хэрэгтэй. Тэгээд олон улсын туршлагаар ингээд энэ ялангуяа энэ критикал эрдсийн жагсаалтыг тухайн уул уурхайн асуудал хариуцсан ЗГ-ын гишүүн баталгаажуулаад, зарлаад явж байна шүү дээ. Эндээ хөрөнгө оруулалт татаад, эндээ стратеги төлөвлөгөө гаргаад. Тэгэхээр энэ тал дээр ямар бодлого цаашид баримтлах вэ?

Мөн Монголчууд ингээд Эрдэнэт үйлдвэр, Багануур уурхайг яагаад эсэргүүцдэггүй вэ гэж би бол өөрөөсөө асууж үзсэн. Тэгэхээр эхлээд төмөр замаа тавиад, тэндээ хотхон байгуулаад, ингээд уурхайчин залуусын гэр бүл нь ажлын байртай, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийгмийн салбарт ажилладаг, нийгмийн үнэлгээгээ хийчихсэн, хүүхдүүд нь гэрээсээ сургууль, цэцэрлэгтээ явдаг. Энэ зүйлийг бүрдүүлж чадсан учраас Монголын ард түмэн дэмжиж, бүгдээрээ энэ уул уурхай өгөөжийг хүртэж, өөрсдөө тэндээ ажлын байртай болж явж байгаа учраас энэ шинэ зүйл биш. Энийг бид хэрэгжүүлэх боломжтой. Тэгэхээр анхнаасаа том стратегийн ийм ордууд дээр стратегийн ашигт малтмалыг цаашдаа нээхдээ ийм суурьшлын бүсүүдийг давхар шийдэж явах ийм л том бодлогыг бид дэвшүүлэх ёстой.

Тэгэхгүй бол ингээд л төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлдээ байшин барилга бариад байвал эндээ шаваад л байна, 4 уулын дундаа. Тэгэхээр энэ нэг том бодлого. Цаашид энийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Бид ямар Канад шиг мянган арлын орон гэж Монголчууд ярьдаг мөсөн дундаас алмаз олборлоогүй. Бид геологийн нөхцөлийн хувьд, байгаа нөхцөлийн хувьд их таатай ийм нөхцөлд байгаа. Цаашдаа гол санал бол геологийг өөрөө улс хийгээд, тэгээд бүгдийг ашиглах албагүй.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Бадамсүрэн гишүүн. Туваан сайд хариулъя, 5 номер.

Ц.Туваан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгээд ер нь Бадамсүрэн гишүүн яг энэ уул уурхайн салбарын мэргэжилтэн инженер хүнийхээ хувиар сүүлийн үед энэ манай энэ салбарын маш чухал асуудлуудыг хөндөж байгаа. Хамтарч ажиллана. Эхнээсээ бид бүхэн яаман дээрээ уулзаад энэ саналуудаа солилцоод явж байгаа.

Хариуцлагатай уул уурхай гэдэг энэ кодексыг хэрэгжүүлэх ажлыг манай салбар дээр ярилцаад явж байгаа. Энийг мэдээж бүтнээр нь яривал нэлээн асуудал болно, цаг хугацаа авна. Энэний гол юм нь ерөөсөө л оролцогч талуудын бүх талын сэтгэл ханамж харилцан ашигтай бүгдээрээ байх гэдэг энэ л зарчим байгаа. Байгаль орчин сэргээгддэг, орон нутгийн иргэд нь харуу, төр засаг нь ч

гэсэн авах татвар хураамжаа аваад явах, компаниуд ч гэсэн ашигтай гэсэн энэ зарчмыг бид баримтлаад явна. Тэгэхээр энэ тал дээр ялангуяа одоо Монгол Улсад орхигдчихоод байгаа орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлага, тухайн орон нутаг нь энэ уул уурхайгаа ашиглуулчхаад хүртэх өгөөжийн асуудлыг нэлээн чухлаар манай Байнгын хорооны дарга болон Бадамсүрэн гишүүн нар манлайлан тавьж байгаа. Тэгэхээр энэ дээр салбарын яам санал нэг байгаа. Шинэ хууль дээрээ энэ асуудлыг нэлээн чухлаар зөв тусгаж өгнө. Дээрээс нь энэ тал дээр Сангийн яамтай ч гэсэн нэлээн ярилцаж шийдвэрлэх талд нь ярьж байгаа гэдгийг хэлье.

Сая энэ критикал минералын асуудлыг хөндөж байгаа. Энэ дээр бид критикал минерал гэдгээ чухал ашигт малтмал гээд ингээд яриад явж байгаа. Энэ дээр нэр томъёоны хувьд ч гэсэн бид эрдэмтэд энэ салбарынхантайгаа ярилцаж байгаад нэг нэр томъёо өгнө. Тэгээд энийгээ салбарын яам нь юм уу, ЗГ батлаад явдаг. Жишээлбэл Австралид гэхэд критикал минерал 36 ашигт малтмал баталчихсан явж байгаа. Энэ дотор бид нарын яриад байгаа газрын ховор элементийн асуудал яригдаж байгаа. Тэгэхээр одоо бид яаман дээрээ ч гэсэн, Ашигт малтмал, газрын тосны агентлаг дээрээ ч гэсэн энэ талын асуудлыг бүүр хэлтэстэй болгоод, хариуцдаг хүмүүстэй болгоод ингээд авч явж байгаа.

Яагаад гэхээр бид сүүлийн жилд оролцож байгаа дэлхийн уул уурхайн чиг хандлага бол шилжилт явж байгаа юм. Уул уурхайн гаднын хүмүүстэй ярихад бараг 60 хувь нь энэ критикал минералын асуудлыг ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид одоо яг энэ дэлхийн хөгжлийн уул уурхайн энэ салбарын алхаанаас хоцрох юм бол хэдхэн жил байгаа, эндээс хоцрох юм бол бид дахиж энэ асуудлыг сөхөх боломжгүй хэмжээнд хүртэл хоцрогдох гээд байгаа. Тэгэхээр таны энэ санаа зовж байгаа асуудлыг бид яам, агентлагийнхаа түвшинд, бодлогынхоо түвшинд авч явж, маш хурдан критикал минералынхаа жагсаалтыг баталж, энэ талын эрх зүйгээ шинэ хуульдаа тусгаад хариуцдаг хүмүүстэй болоод явах ажлыг хийж байгаа гэдгийг хэлье.

Мэдээж тэр уул уурхай дагасан тэнд ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудал, ялангуяа тэр амьдрах орон байртай холбоотой асуудал дээр тантай санал нэг байна. Энэ дээр бид түрүүний хэлсэн тэр хариуцлагатай уул уурхайнхаа хүрээнд энэ асуудлаа аваад явна. Тэгэхээр бид нарын зорьж байгаа хууль, эрх зүйг цогцоор нь хийх гэдэг дотор энэ уул уурхайн салбарт ажиллаж байгаа Монгол иргэдийн нийгмийн асуудлууд чухал байр суурь эзлээд явах нь зөв гэдэг дээр байр суурьтай байгаа.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн тодруулж асууна.

М.Бадамсүрэн: Тэгэхээр нөгөө улсын төсөв дээр хэдэн төгрөг геологийн судалгаанд тавих вэ гэж ингэж хараат байдлаар байх биш энэ шинээр өргөн барих Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга дээрээ уул уурхайн салбараас хэдэн төгрөг олж байна тэдний тэдэн хувь нь геологийн салбартаа, тэгэхдээ энийгээ төр өөрөө хийгээд, тэгээд төр өөрөө нөөцөө энд нь уул уурхай явуулъя, энийг нь хойч үедээ үлдээе, энд нь мал аж ахуй, энд нь аялал жуулчлал явъя гэдгээ ингэж уулын орой дээрээс харж байгаад ингээд том тодорхойлохгүй бол болохгүй байгаа.

2 дугаарт нь нээлттэй тендер шалгаруулалтыг уул уурхай буюу эдийн засгийн хамгийн том хамгийн их худалдан авалт явдаг салбарт бид заавал нэвтрүүлэх хэрэгтэй. Энийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэлд хамруулах энэ зүйлийг юун дээр оруулж өгөх хэрэгтэй. Ингэснээрээ уул уурхайн байдлын ил тод, хариуцлагатай уурхай чинь нэг талаараа хангагдана. Ийм бодлогын томоохон зүйлүүдийг хуульчилъя л гэдэг саналтай байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр яамны байр суурийг сонсьё.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Улсын төсвийн хөрөнгө хязгаартай. Тэгэхээр мэдээж маш олон асуудлыг шийдвэрлэх учраас энэ асуудал мөнгө төгрөг, ялангуяа санхүүгийн асуудлууд хязгаартай. Тэгэхээр бид энэ дээр энэ жил ч гэхэд жишээлбэл бид уул уурхай, ялангуяа геологийн судалгаа дээрээ нэлээн хоцрогдлоо арилгах, орчин үеийн агаарын соронзон геофизикийн судалгаа дээрээ нэлээн мөнгө тавиад орсон, 40 тэрбум төгрөг тавиад орсон. Харамсалтай нь 20 тэрбум төгрөг нь хасагдчихсан ингээд явж байх жишээтэй. Тэгэхээр энэ асуудлаа бид цаашдаа ингээд нэлээн аваад явна. Нарийвчилсан судалгаа дээр хөрөнгө оруулалт нэлээн шаарддаг, хувийн хэвшлийнхэн дангаараа хийгээд авч явах боломжгүй ийм зүйл байгаа учраас бид энэ тал дээрээ хөрөнгө оруулалтаа цаашдаа бууруулахгүйгээр ингээд аваад явна гэдэг ийм байр суурьтай байгаа. Мэдээж хууль дээр хэдүүлээ нэлээн удаан тогтож ярина. Тэгээд таны саналуудыг аваад, тусгаад хамтдаа.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулах уу? Нээлттэй тендер.

Ц.Туваан: Сая өмнө нь энэ гишүүдийн асуултад гарсан. Ил тод байдал нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, дээрээс нь уул уурхайн салбарын ерөөсөө салшгүй нэг хэсэг бол уул уурхайн салбарын ханган нийлүүлэлтийн асуудал байгаа. Тэгэхээр ханган нийлүүлэлтийг нийлүүлэлтэд маш олон ялангуяа орон нутгийн компаниуд маш ихээрээ оролцож, тэнд бүтээгдэхүүнээ янз бүрийн ажил, үйлчилгээ нийлүүлэх ийм боломжтой байдаг. Тэгэхээр энэ дээр тодорхой хуульчлаад өгсөн ч зөв байх гэсэн ийм байр суурьтай байна. Тэгэхгүй бол нөгөө мэдээлэлд ойрхон ч юм уу, эсхүл томоохон ч юм уу, эсхүл танил талтай компаниуд нь авчхаад, бусад орон нутгийн арай жижиг, дөнгөж гарааны энэ компаниуд оролцох нөхцөл байдал бол хязгаарлагдмал байгаа тал яг бодитойгоор байгаа. Тэгэхээр энийг.../минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Уул уурхайн салбар манай эдийн засгийн том чухал ач холбогдолтой салбар, тэгээд бүгд л хэлж байна. Экспортын гол орлого, төсвийн орлогын дунджаар 30 хувь энэ тэр гээд. 2011 онд чинь чухам манай Монгол Улс чинь хамгийн хурдтай өсөж байгаа эдийн засагтай улс гээд нэрлэгдэж байлаа гэх мэт гээд сайн зүйлүүд байгаа. Тэгээд бусад олон улсын туршлагыг харахаар баялгийн хараал болох уу, ерөөл болох уу гэдэг энэ онол байна, яриа, юу байна практик туршлагууд. Тэгээд энэ маш их олны анхаарал татсан салбар. Өнгөрсөн жилүүдийг ажиглахаар хууль, эрх зүйн орчин зохистой хэмжээнд тодорхойлогдоогүй, тухайн орон нутагт ер нь олон нийттэй харилцах харилцаа хангалттай байгаагүй буюу мэдээлэл ил тод биш, байнгын тогтмол урсгалтай биш

байсан зэргээс болоод нэлээн ийм өм цөм асуудалд орж байсан ийм салбар байгаа.

Тэгээд одоогийн байдлаар Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсэг гэж байгуулагдсан байгаа. Сая сайд ч өөрөө яриад байна. Би өөрөө тэр ажлын хэсэгт байгаа. Дээр яаман дээр очиж уулзах уулзалтад энд хурал давхцаад очиж амжаагүй. Өмнө нь би Нээлттэй нийгэм форумд ажиллаж байсан. Манай форум тухайн үед 2012 онд, сүүлд 2 мянга их оноо мартчихаад байна, 17 онд байна уу 2 удаа ийм сценари боловсруулж байсан юм. Уул уурхайн баялгаас орж ирж байгаа орлогын менежмент ямар байхаас шалтгаалаад тухайн хувь иргэн хүний амьдрал 4 янз байж болно. Хамгийн бестээрээ орлогоо, хамгийн сайнаараа орлогоо менеж хийвэл дундаж иргэний амьдрал ямар байх вэ гэдэг ч юм уу, хамгийн муугаар орлогоо менеж хийвэл, удирдах юм бол ямар байх уу гээд. Гочоогийн 4 тавилан, Заяагийн 4 тавилан гээд. Та нар сонирхож харж болно.

Тэгээд зарим нэг байдлыг нь эргээд харахаар нь яг тэр сценар шиг яваад байна гээд бас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байсан Энхбат гуай энэ тэр сошиал медиа дээр постолж байсан гэх мэт. Миний оршил урттайгаар ярих гээд байгаа гол санаа нь олон санаанууд байна, олон, том асуудал учраас мэдээж. Зүгээр нэг асуудлыг хөндөхөд рояалти буюу ашигт малтмалын нөөцийг ашигласны төлбөрийг тусгай хуулиар зохицуулах, тусад нь гаргах гэдэг дээр таны санал ямар байгаа вэ? Танай салбарын хүмүүсийн санал ямар байгаа вэ гэдэг дээр товчхон асуучихъя даа.

Р.Сэддорж: Хэн хариулах вэ? Туваан сайд, бусад хүмүүс хариулж болно. Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Мэдээж чухал салбар. Өнөөдрийн байдлаар бид энэ баялгийн хараал ч гэж ярьдаг, Голланд өвчин ч гэж ярьдаг энэ асуудлууд бодитойгоор байгаа байгаа, тэрийг нуухгүй. Тэгэхээр энэнээс яаж хурдан гарах вэ гэдэг л асуудлууд байгаа. Тэгээд түүн дээр Улсын Их Хуралтайгаа хамтарч ажиллаж байж гарна. Хууль, эрх зүйгээ сайжруулж байж гарна. Энэ олон журмуудыг хууль, эрх зүйд нь нийцүүлж, органик хуулиараа зохицуулдаг болж байж гарна л гэсэн ийм бодлоготой байгаа.

Таны саяын хэлсэн энэ Нээлттэй нийгэм форумын гаргасан уул уурхайн баялгийн орлогын менежментийн тайланг авч үзье. Манай энэ газрын дарга нараас үзсэн судалсан байх гэж ингэж бодож байна.

Рояалти дээр ийм л байгаа. Мэдээж энэ рояалти менежмент гэдэг юмыг маш сайн хийх ёстой энэ дээр санал нэг байгаа. Гишүүдийн байр суурь ч гэсэн, манай яамны байр суурь ч гэсэн энэ дээр нэгдээд байгаа. Энэ дээр бол хийхээс өөр арга байхгүй. Бид энэ рояалти менежментээ уг нь хууль дээрээ зааж өгсөн. Түүн дээр юу гэхээр энэ байгаль, уул уурхай ашиглаж байгаа улс орон бол тэр рояалтины тодорхой хувийг 30-аас 40 хувийг аваад, тэрийгээ орон нутгийн ашиглуулж байгаа тодорхой хэмжээнд өөрсдийнхөө эрх ашгийг зөрчүүлж байгаа орон нутгийн иргэд нь ашиглах гэдэг энэ зүйлийг гаргасан. Тэгэхдээ мэдээж энэ хууль хэрэгжих явцдаа мөн төсвийн орлого бүрэлдүүлэх энэ явцдаа бид орон нутгийн төсөв дээр орох орлогыг нэгдсэн төсөв ч гэдэг юм уу иймэрхүү байдлаар ингээд найруулаад, улсын төвдөө татаж аваад, бүх зүйлүүд нь тэгшитгэн хуваах гэдэг энэ зарчмаар явчихсан асуудал бол өнөөдрийн яг уул уурхайн хөгжилтэй

зөрчилдөж байна. Яагаад вэ гэхээр ашиглуулаад тодорхой хэмжээний хохирол, малын бэлчээр ч юм уу, тариалангийн газраа ч юм уу бусад асуудлуудаа өгөөд тэнд нэлээн тийм байгаль орчинд сөрөг нөлөөтэй байгаа газрууд нь илүү ашиг хүртэж чадахгүй байгаа байдал нь өнөөдөр энэ салбарын хөгжилд хамгийн том чөдөр тушаа болж байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь энэ рояалтийн хувьд бид сая 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө Баялгийн сангийн тухай хууль буюу Норвегийн сангийн маягийн хууль батлаад, энэ үр өгөөжийн дийлэнх хэсгийг ард иргэд маань хүртдэг байя гэдэг энэ Үндсэн хуулийн зарчмаа хийчихсэн, дагуулаад хуулиа баталчихсан. Дээрээс нь дахиад рояалти менежмент дээр сая энэ төрийн эзэмшлийн ялангуяа энэ стратегийн ордуудын хувийг бид Цөмийн энергийн хуульдаа өөрчлөлт оруулаад энэ тусгай рояалти-р сольж болно. ЗГ-ын тогтоолоор энэ стратегийн орд газруудын 34 хүртэлх хувь дээр ярилцаж, яаж шийдэх вэ гэдэг асуудлууд гээд ингээд янз янзын вариантууд гаргаад ярьж байгаа гэдгийг танд хэлье. Тэгэхээр энэ асуудлууд цаашаа нэлээдгүй яригдаж явна.

Яагаад вэ гэхээр ард иргэд маань Хуримтлалын сантай болчихсон, Баялгийн хуультай, Хуримтлалын сантай, бүгд өөрсдөө данстай болчихсон. Одоо энэ дансаа аль болох яаж хурдан мөнгөжүүлэх вэ гэдэг асуудал дээр бүгд анхаарал тавьж байгаа учраас ЗГ энийг мөнгөжүүлж аль болох иргэнд тэр яриад байгаа орон сууц, боловсрол, эмчилгээнийх нь асуудлыг шийдэхүйц хэмжээний орлого оруулахын төлөө ажиллана гэдгийг хэлье. Түрүүн гишүүдийн санал дээр гарч байсан Сайнзориг гишүүнийх дээр. Энэ Ашигт малтмалын тухай хуулиасаа тусад нь энэ Амнатийнхаа хуулийг, ялангуяа энэ татварын асуудал эрхэлсэн байдлаар Татварын хуульдаа зохицуулалт оруулаад явчхаж болдоггүй юм уу гэдэг асуудал байгаа. Энэ тал дээр бид нээлттэй ярилцах боломж байгаа. Та ажлын хэсгийн гишүүний хувиар саналаа хэлээд, хэдүүлээ ярилцаад, шийдвэр гаргаад явъя гэсэн ийм саналтай байна.

Р.Сэддорж: Мөнхсоёл болсон юм уу? Тодруулъя. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Тодруулах биш ээ, зүгээр саналаа хэлчихье. Нөгөө revenue sharing mechanism гэж байгаа шүү дээ. Сая өөрийн чинь ярианд орсон нөгөө орон нутагт тухайн баялагтай орон нутаг баялгаасаа хүртэхгүй байна гэдэг асуудлаар өчнөөн асуудал гардаг үнэн. Тэгээд нөгөө механизм дотор чинь олон сангууд байгаа. Орон нутгийн хөгжлийн санд тодорхой хувь очиж байна ч гэдэг юм уу. Үндэсний баялгийн сан энэ тэр гээд сангуудаар дамжиж байна. Хуучин янз бүрийн томъёонууд байсан. 30 хувь нь ч аймгийн түвшинд, сумын түвшинд энэ тэр гээд хуваагддаг зүйлүүд байсан, буцсан, ухарсан. Ингээд байнга орон нутгийн иргэд сэтгэл хангалуун биш байдаг. Түүн дээр олон хүчин зүйл нөлөөлдгийн нэг нь тухайн тухайлбал Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг шийдэхдээ орон нутгийн иргэдийн оролцоог бий болгох ёстой байсан гол зорилго нь. Өөрөөр хэлбэл санхүүгийн төвлөрлийг, эрх мэдлийн төвлөрлийг багасгаж, иргэдэд decentralization хийх буюу төвлөрлийг сааруулах замаар иргэдэд санхүүгийн эрх мэдлийг тодорхой хэмжээнд олгоё гээд. Гэтэл бодит байдал дээрээ Засаг дарга нь шийддэг ч юм уу, нөгөө эрх мэдэлтэй хүмүүс нь шийдээд.../минут дуусав/

Р.Сэддорж: Уул уурхайн яам хамтарсан ЗГ-ын Уул уурхайн яам ажлаа үргэлжлүүлээд энэ шинэ 4 жилийн эхэн дээр олон ажлуудаа амжуулж байгаад баяр хүргэе. Талархаж байгаа. Тэгээд та бүгдийг ард иргэд маань их хүлээлттэй

хүсэн хүлээж байгаа. Тэгээд та бүгд маань энэ хамтарсан ЗГ-ын үед шийдэж чадахгүй байгаа томоохон хуулийн өөрчлөлт эд нараа оруулахаар бэлдэж байгаа. Энэ үнэхээр ард иргэд тэр уул уурхайтай аймаг, сумдын ард иргэдийн зовлон бэрхшээлийг ойлгож, нимгэлэх, дээрээс нь уул уурхайтай, уул уурхайг хөгжүүлэхийг хүсэж байгаа, уул уурхай хэрэгтэй юу, хэрэггүй юу гэж бодож тээнэгэлзэж байгаа аймаг, сумын ард иргэдэд тодорхой, ойлгомжтой ийм хуулийн зохицуулалтуудыг та бүхэн маань хийж, энэ дээр бүх анхаарал, цаг хугацаагаа зарцуулахыг хүсье.

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд аймаг, сумын иргэдийн хурлаасаа санал авдаг, тэрэнд нь ард иргэд их дуртай, маш няхуур хэлэлцдэг байсан бол одоо яван явсаар сумын иргэдийн хурал, багийн иргэдийн хурлын шийдвэр саналууд зүгээр хуулийн шаардлагад нийцээгүй бол шууд дээрээс нь лицензийг олгодог, ингээд эргээд ийм болчихсон байгаа. Тэгэхээр ахиц дэвшлээ олсон хэдий ч ухраад байгаа явдал бол ард иргэдэд ойлгогдохгүй байгаа. Та бүхэн маань хэд хэдэн асуудлыг анхаараарай.

Эрдэнэс тавантолгой уурхай, Монголчуудын маань хамгийн 1072 хувьцаа эзэмшдэг хамгийн томоохонд тооцогдох уурхайн тэр сумынх нь сургууль нь нурчихсан, нэг сургууль нь царцчихсан, хүүхдүүд нь энд, тэнд хуваагдаад хичээл хийж байгаа. Жишээ нь томоохон уул уурхайн аймаг бол Өмнөговь аймаг. Өмнөговь аймаг дулааны цахилгаан станцаа энэ жил эхлүүлээгүйн улмаас халаалт нь доголдоод, байшин барилгууд айл өрхүүд даарсан хамгийн их нүүрстэй, хажуудаа их нүүрстэй, уурхайтай хэр нь ийм байдалтай байгаа.

Дээрээс нь усны асуудал байна. Тэгээд 14 мега төслийн хэдэд нь энэ усны асуудлаа оруулж ирэх вэ? Энэ дээр ямар бодолтой байна вэ? Тэгээд олон говийн бүсийн Монгол орны энэ гол мөрөнгүй бүхий л аймгийн хүмүүс бол энэ төслийг амжилттай яваасай гэж хүсэн хүлээж байгаа. Тэгээд энэ санал, асуултаа ингээд хамтатгаад та бүхэнд тавьж байна. 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Бид алтыг нь аваад, авдрыг нь хаядаг байдлаар биш, алтаа өгч байгаа ард иргэд нь өөрсдөө харуу байх энэ асуудлыг л нэлээн бодлогын түвшинд авч явна гэж бодож байгаа. Тэгээд ер нь нөгөө хэн хэн нь харуу хонь нь бүрэн, чоно цатгалан гэдэг шиг ашиглуулж байгаа уул уурхайн дэмжиж байгаа ард иргэд илүү боломж нөхцөлтэй байх, илүү нийгмийн, санхүүгийн асуудлуудаа шийдвэрлүүлдэг байх гэдэг ийм зарчмыг барьж ажиллах ажиллана гэдгийг хэлье. Сэддорж даргын хувьд энэ уул уурхай түлхүү Монгол Улсыг тэжээж байгаа Өмнөговь аймгийн удирдлагаар ажиллаж байсны хувьд энэ асуудлуудыг нэлээн чухалчилж авч үзэж байгаа. Тэгээд манай харьяалагдах салбарын яамны хувиар энэ зүйл дээр нэлээн хамтарч ажиллана. Тэгээд энэ долоо хоногт Тавантолгой, Оюу толгой гээд томоохон төслүүдээр явах байх. Бид ч гэсэн энэ дээр өндөр түвшнийхээ яамны удирдлага, газрын дарга оролцоод шийдлүүдээ газар дээр нь хараад ирнэ. Энэ нь эргээд бид нарын дараагийн гаргах шийдвэр дээр нэлээдгүй чухал ач холбогдолтой болно гэж ингэж харж байгаа.

Тэр бодлого буруу байгаа. Түрүүний тэр Орон нутгийн хөгжлийн сан дээрээ тодорхой 30 хувь, 40 хувь авдаг асуудал нь хуульд нэмэлт, өөрчлөлт Орон нутгийн нэгдсэн сан гэдэг тэр нэг үгнээс болоод ингээд улсдаа төвдөө татагдаад, тэгшитгэн хуваарилагддаг зарчмаар явж байгаа энэ бодлого бол нэг үе төсөв бүрдүүлэхэд хэрэгтэй байсан байх. Одоо бид энийг нэлээн ярихгүй бол уул уурхай дэмждэг

орон нутаггүй болох гэж байна. Тэгэхээр энэ асуудлууд бид нарт ялангуяа бид нэлээн том зорилго тавьчихсан иргэдийнхээ эдийн засгийнхаа асуудлыг шийдэх зорилго тавьчихсан байгаа энэ цаг үе дээр бодлогын зөрчил болно. Тэгэхээр энийг шийдэж байж явна гэсэн ийм зорилготой ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Цогтцэцийн сургуулийн дээврийн асуудал тэгээд л бид яг энэ гол манай уул уурхай ашиглаж байгаа суман дээр ийм асуудал байгаа гэдгийг салбар яамны хувьд сонссон. Өмнөговийн дулааны цахилгаан станцыг сонссон. Тэгээд энэ нөгөө яг бодлогын алдааны л нэг хэсэг гэж ойлгож байгаа. Усны хувьд 14 мега төсөл дээрээ бид Хэрлэнтооно, Орхон-Онги гээд оруулчихсан явж байгаа. Тэгээд энэ асуудал судалгааныхаа хүрээнд нэлээн асуудалтай, ялангуяа говийн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийнхээ хамт ажиллагааны хүрээнд даруйхан шийдлийг хэлнэ. Нэлээн томоохон зорилтуудыг тавьчихсан явж байгаа. Тэгээд энэ дээр энэ хариултын цагт дамжиж болохгүй байна. Тэгээд танд дараа тодорхой хариултуудыг.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг баримтлан боловсруулсан Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Ашигт малтмал, газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн санд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн улсын төсөвт төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг хуваарилах чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын ЗГ-т чиглэл болгож байна гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг санаачлагч Бадамсүрэн гишүүн та тайлбарлах уу? Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Баярлалаа. Энэ сая сайдын зүгээс, яамны зүгээс энэ зүйлийг ойлгож, Сангийн яамтай харилцаж байгаа гэж би мэдээлэл авлаа. Ер нь эцэг өвгөдөөсөө энэ хязгаар нутагт нүүдэллэж амьдарсан тэр малчин иргэд, сумын иргэд, хөдөө орон нутгийн иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжих асуудал хамгийн чухал асуудал байгаа тэгээд. Тийм учраас энэ тогтоолын төслийг санаачилж Байнгын хороондоо танилцуулсан. Тэгэхээр энэ тогтоолын төслийг манай Байнгын хорооны гишүүд дэмжиж өгөхийг хүсье.

Яагаад гэвэл энэ бол цаашдаа уул уурхайн салбарыг хариуцлагатай, ил тод, орон нутаг, Монголчууд, нийт Монголчуудад өгөөжтэй байхад чухал хувь нэмэр оруулна гэж тооцож байна. Тэгэхээр бүгд энэ зүйл дээр ер нь олон удаагийн хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, ажлын хэсэг гээд олон

түвшинд ингэж санал нэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ зүйлийг салбарын сайдын хувьд ЗГ-т шуурхай энэ зүйлийг урагшлуулахын тулд санаачилгатай ажиллаач гэж хүсэж байна. Байнгын хорооны гишүүдээсээ дэмжиж өгөхийг хүсье. Байнгын хорооны даргадаа баярлалаа.

Р.Сэддорж: Тогтоолын төсөлтэй саналтай гишүүд байна уу? Төсөл дээр. Асуулт, саналтай гишүүд байна уу? Сайнзориг гишүүн юугаа дарчих. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Мөнхсоёл гишүүн ч хэлээд байгаа юм. Би таныг орж ирэхээс өмнө асуусан юм. Тэгээд энэ уул уурхайн салбарын хуулийг хөндөх гээд тэгэхээр Амнатийн асуудал ч юм уу давхар хөндөгдөөд л ингээд зарим яг энэ мэргэжлийн хийх ёстой ажлууд нь хоцорчхоод байдаг юм байна лээ. Тэгэхээр уг нь хууль зүйн техникийн хувьд бололцоотой бол Ашигт малтмалын хуулиа 2 салгаад яг татварын бодлоготой буюу Амнатийн хэсгээ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль гээд бие даалгаад, бусад асуудлаа уг нь бол Ашигт малтмалын хууль гээд нэрлээд явчихмаар байна. Эсвэл Эрдэс баялаг, ашигт малтмал ч гэдэг юм уу.

Ингэчихвэл мэргэжлийн яам нь ажлаа хийгээд, шаардлагатай бол төсвийнхөө бодлоготой уялдуулаад, орон нутаг энэ тэртэйгээ явах юм байна лээ. Тэгээд энэ хуулийн хэрэглээ нь өөрөө Төсвийн хуулийг дагаж орж ирээд уул уурхайн салбарын бодлого алдагдчихдаг, эсвэл Газрын хууль дагаж орж ирээд шал өөр болчихдог ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ зүгээр би хүчээр Бадамсүрэн гишүүний юун дээр нэммээргүй байна зүгээр энэ хууль тогтоомжийн Амнатийн бие даасан асуудлыг бие даасан хуулиар ингэхийг зүгээр судлах, судалж танилцуулах гэдгийг зүгээр дурдвал дурдчих юм, байж болох уу л гэдэг байна. Тэгвэл яах вэ зүгээр амар ажлын хэсэг дээр бас Байнгын хороо. Тэрнээс биш заавал салга гэж байгаа юм биш, сайн тооцно биз, сайн уялдааг нь харна биз. Тэгэхдээ яах вэ, зүгээр татварын хуулийг зөвхөн татварын хуулиар зохицуулна л гэсэн зарчим ганцхан энэ Ашигт малтмалын хууль дээр л алдагдчихаад байгаа юм. Тэгээд энийг зүгээр бодолцоод, шаардлагагүй гэвэл хэлэхгүй. Би зүгээр яах вэ энэ Байнгын хорооноос өгч байгаа чиглэл дээр хууль боловсруулах ажлын хэсэг дээр яах вэ зүгээр нэг дэм болох юм болов уу даа л гэж бодох юм зүгээр, бас нэг их, тэгээд Туваан сайд шаардлагагүй гэвэл яах вэ ЗГ-ын байр суурийг нэг сонсчихъё.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ дээр Сангийн яамтай сүүлийн үед нэлээн ярилцаж байгаа. Тэгээд тэднийхэн бол Сангийн яамныхан бол нэлээн дэмжих хандлагатай болсон байгаа. Тэгэхээр энэ талын асуудлыг ярилцаж болох байх. Тэгэхдээ ер нь нэг хэсэг хугацаанд юу гэдэг юм тодорхой энэ бодлого нь шийдвэр болоод ингээд явах хүртэл хугацаанд ашигт малтмалын нөөц ашигласны татварын асуудал салбарын яамныхаа, салбарын хууль дээрээ байсан нь зүгээр ч байж магадгүй. Яагаад гэхээр түрүүн би хэлсэн. Энэ Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлоготой холбоотой асуудал дээр гэхэд л нэгдсэн сан гэдэг үг орж ирээд л энэ асуудал төвдөө татагддаг болчихсон байх жишээтэй. Тэгэхээр нөгөө салбарын яамны бус энэ салбарын хуулиар зохицуулагдаагүй үед өөрчлөгдөөд нөгөө тийшээгээ яваад өгчих эрсдэл байгаа учраас нэлээн хашир судалгаатай хандвал дээр байх гэж ингэж бодож байна.

Дараагийн нэг асуудал яах вэ энэ салбарын сайд биш, ер нь Их Хурлын гишүүнийхээ хувиар хэлэхэд манай уул уурхайн салбар дээр энэ тэртээ тэргүй санхүү мөнгөтэй ч гэдэг юм уу, энэ янз бүрийн асуудлыг шийдэхэд нэлээн тийм хойш нь тавих байдал анзаарагддаг. Тэр нь та бүхэн анзаарсан бол хамгийн сүүлийн 25 оны төсөв дээр гэхэд манай яам дотоодын нийт бүтээгдэхүүн, төсвийн орлого, экспортын орлогын маш өндөр хувиудыг бүрдүүлдэг мөртөө төсөв санхүүгийн хувьд гэхэд л доороосоо 2-т, сүүлээсээ 2-т явж байх жишээтэй. Тэгэхээр тийм нэг ийм зөрөлдөөнтэй ийм логик яваад байгаа юм. Тэгэхээр бид энэ салбарыг хөгжүүлэхэд саяын энэ ярьсан бодлогуудыг, ялангуяа энэ хариуцлагатай уул уурхай, Амнат, усны, энэ рояалти хуваарилалт гээд энэ, энэ асуудлуудыг шийдэхэд бид нарт төсөв, санхүү хэрэгтэй байдаг юм шүү. Тэрийг манай харьяа Байнгын хорооныхон маань ойлгож, дэмжиж, цаашдын юман дээрээ дэмжиж өгөөсэй гэсэн ийм хүсэл байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Энэ олон гишүүдийн ярьдаг сэдвийн нэг. Тэгээд энэ 30 хүртэл гэдэг зохимжтой үг байх гэж бодож байгаа. Би түрүүнд энэ тогтоолын энэ үг хэлэх юун дээр хэлчихье. Тэгээд Эрдэнэс Тавантолгой компани тэр нийгмийн хариуцлагын хүрээнд юу өгдөг, тэр юун дээр ТУЗ-ийн даргад нь танилцуулсан байна лээ Цогтцэций сумын. Нурчихсан шүү дээ дээвэр биш, бүр тэр чигээрээ нурах түвшинд оччихсон. Тэгээд нийгмийн хариуцлагын хүрээнд тэрийгээ 9,7 тэрбум төгрөг юм байна лээ. Анги ангиараа өөр, өөр байшин сав түрээслээд ингээд яаж байгаа, хичээллэж байгаа. Тэрийг анхаарна биз. Станцын асуудлыг та бүхэн маань яамныхаа хэмжээнд дэмжээрэй. Сангийн яам бонд гаргахаар судалж байгаа. Тэгээд энийг та бүхэн дэмжээрэй гэдгийг хэлье.

Бадамсүрэн гишүүний санаачилсан Байнгын хорооны тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор, гишүүд байраа эзэлье, баталъя гэсэн томьёоллоор санал хураалт. Соронзонболд гишүүнийг нэмье гэсэн. Соронзонболд гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна.

Л.Соронзонболд: Саяын санал хураалтыг цуцалж өгөхийг санал хураалт явуулъя. Хүчингүй болгоод.

Р.Сэддорж: Техник гацсан, санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргасан байна. Горимын саналаар санал хураалт. Техникууд бүгд ийм гацаж байгаа учраас санал хураалтыг хүчингүй болгоё. Тогтоолыг, илээр санал хураая. Горимын санал. Илээр санал хураах горимын саналыг 14-өөс 8. Ингээд горимын санал дэмжигдлээ. Тогтоолыг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт. 14-өөс 8 гишүүн дэмжиж, Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

21.34 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөж байна. Уул уурхайн яамныхаа хамт олонд ажлын амжилт хүсье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

